



## ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН РЕДАКТОР, СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот

2021 он

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН ВАКЦИНУУДЫН ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТОЙМ

---

Дархлаажуулалтын хүрээнд 2021 онд Монгол улсын хүн амын 60%-д тус бүр 2 тун вакцин хийхээр төлөвлөж, Засгийн газраас 226 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна. Эхний ээлжинд дараах төрлийн вакциныг Монгол улсад оруулж ирэх шийдвэр гаргасан. Үүнд:

1. Их Британи-Шведийн "AstraZeneca" компани ба Оксфордын их сургуулийн эрдэмтдийн хамтран гарган авсан Ковид-19-ийн эсрэг AZD1222 вакцин
2. АНУ-ын Pfizer ба Германы "BioNTech" компаниудын хамтран бүтээсэн "BNT162b2" вакцин
3. БНХАУ-ын "Синофарм" компани, Бээжингийн биотехнологийн хүрээлэнгийн хамтран гарган авсан "BBIBP-CoV" вакцин
4. Ковид-19-ийн эсрэг хамгийн анхны вакцин гэгдэх ОХУ-ын "Спутник-V" /Гам-КОВИД-Вак/ вакцин

### 1. Астра-Зенека вакцины тухай товч тойм

Английн Оксфорд их сургуулийн гарган авсан Астра-Зенека (AZD1222, ChAdOx1 nCoV-19, Covishield, Vaxzevria) вакцин нь сулруулсан аденовирусын вектор вакцин бөгөөд дархлаа тогтоох чадвар нь эхний тунг хийлгэснээс 22 хоногийн дараа 76%, 2-дох тунг 12 долоо хоногийн дараа хийхэд 81.3% болж өссөн байна. Харин эхний тунгаас 4 долоо хоногийн дараа 2 тунг хийхэд 15 хоногийн дараа дархлаа тогтоц 76%тай байв. Энэхүү вакцины ерөнхий болон хэсэг газрын хариу урвалууд болох толгой өвдөх, булчингаар өвдөх, үе мөчөөр өвдөх, халуурах, тарьсан газар өвдөх шинж тэмдэг 10 хүн тутмын 1-д тохиолдож болох ба шинж тэмдгүүд ихэвчлэн хөнгөнөөс дунд зэргийн, залуу хүмүүст (55-аас доош насны) хүмүүст илүү тохиолдож байсан байна. Европын холбооноос гаргасан баримтанд анафилаксын урвал 11.7 сая хүнд 234 тохиолдсон гэж тэмдэглэсэн байна. Мөн Европын хэд хэдэн улс тархины цусны бүлэгнэлийн тохиолдлыг бүртгэж, АстраЗенека вакциныг

хэрэглэхийг түр зогсоосон байна. Европт нийт 5 сая гаруй хүн энэхүү вакциныг хийлгэснээс 30 дээрх тохиолдлыг бүртгэгдсэн байна.

2021 оны 4 сарын 7-нд Европын холбоо Астразенека вакцины хариу урвалд маш ховор тохиолдох тархины судасны битүүрлийг бүртгэсэн. Судалгаанд архаг суурь өвчтэй хүмүүс оролцсон бөгөөд судалгааны үр дүн эрүүл хүмүүстэй адил байсан байна. Мөн ДЭМБ-аас хөхүүл болон жирэмсэн эмэгтэйчүүд сонголтоороо энэ вакциныг хийлгэхийг зөвлөсөн байна. Тохиромжтой тун хоорондын зайг бүрэн судалж дуусаагүй бөгөөд одоогийн байдлаар улс бүр харилцан адилгүй хугацаагаар 2 дахь тунг хэрэглэж байна. Их Британи, Австралийн Квинсланд муж 12 долоо хоног байхаар хэрэглэж байна. ДЭМБ-аас 2 дахь тунг 8-12 долоо хоногт хийхийг зөвлөжээ.

Эх сурвалж:

1. [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(21\)00432-3/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(21)00432-3/fulltext)
2. <https://www.medicalnewstoday.com/articles/oxford-astrazeneca-vaccine-what-to-know-about-side-effects>
3. [https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/977237/Coronavirus\\_vaccine-summary\\_of\\_Yellow\\_Card\\_reporting\\_28.03.21.pdf](https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/977237/Coronavirus_vaccine-summary_of_Yellow_Card_reporting_28.03.21.pdf)
4. <https://www.medicalnewstoday.com/articles/oxford-astrazeneca-vaccine-what-to-know-about-side-effects>
5. <https://www.medicalnewstoday.com/articles/astrazeneca-vaccine-3-month-dosage-interval-might-be-preferable#Doses-and-intervals>
6. <https://www.who.int/news-room/feature-stories/detail/the-oxford-astrazeneca-covid-19-vaccine-what-you-need-to-know#:~:text=Vaccination%20can%20be%20offered%20to,of%20breastfeeding%20after%20vaccination.>

## 2. Pfizer-BioNTech вакцины тухай товч тойм

Pfizer-BioNTech (BNT162b2) вакцин нь Германы BioNTech, Америкийн Pfizer компаниудын хамтран гаргаж авсан mRNA вакцин юм. Вакцины туршилт 40000 хүнийг хамарч хийгдсэн ба 2 дахь тунг хийлгэснээс 7 хоногийн дараа 91.3% дархлаа тогтож байгааг тогтоосон байна. Тарьсан газар өвдөх, ядарч сульдах, толгой өвдөх зэрэг ерөнхий урвалын шинж тэмдгүүд илрэхээс гадна харшлын урвалууд маш ховор тохиолдож байгааг тэмдэглэсэн байна. Судалгаанд нийт 40277 хүн оролцсоноос 18592 (46.2%) нь ямар нэгэн архаг хууч өвчтэй байснаараа онцлог байна. Үүнээс таргалалттай 35.1%, артерийн даралт ихсэх өвчтэй 24.5%, чихрийн шижинтэй 8.4%, уушгины архаг бөглөрөлт өвчинтэй 7.8%, зүрхний шигдээстэй өвчтөн 1% байсан байна. Судалгааны дүнгээр 2 дахь тунг хийсний дараа 7 хоногийн дараа үзэхэд архаг хууч өвчтэй (at least 1 Charlson comorbidity index) хүмүүст дархлаа тогтох чадвар 95.4%, таргалалттай хүмүүст 95.5% үр дүнтэй байжээ. Энэхүү вакцины 2 тун хоорондох хугацааг 21 хоног гэж Америкийн өвчний хяналт ба урьдчилан сэргийлэх төв (CDC)-өөс албан ёсоор зөвлөсөн байна. Харин энэхүү вакцин нь жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд туршигдаагүй ба зүрхний архаг дутагдалтай, хүндэрсэн чихрийн шижин, захын судасны эмгэгтэй, элэгний өвчин, дархлаа дарангуйлагдсан, ДОХ-той хүмүүсийг оролцуулсан боловч хүмүүст вакцин хэрхэн нөлөөлөх нь тодорхой бус байна.

Эх сурвалж:

1. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7745181/>
2. <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/vaccines/different-vaccines/Pfizer-BioNTech.html>
3. <https://www.fda.gov/media/144245/download>

### 3. Синофарм вакцины тухай товч тойм

БНХАУ-ын үйлдвэрлэсэн Синофарм вакцин (BBIBP-CorV) нь идэвхгүйжүүлсэн вирусын вакцин бөгөөд 12 сарын 30-нд Арабын Нэгдсэн Эмират улсад явагдсан 3-р шатны туршилтаар COVID-19 вирусын эсрэг дархлаа тогтоох чадварыг 86% гэж тодорхойлсон байна. Мөн туршилтаар COVID-19 халдварын хүндрэлээс урьдчилан сэргийлэх чадвартайг нь нотолжээ. 3-р шатны туршилтанд Аргентин, Бахрайн, Египет, Мороко, Пакистан, Перу болон Арабын Нэгдсэн Эмират улсад нийт 60000 хүн оролцсон байна. Тухайлбал: Арабын Нэгдсэн Эмират улсад нийт 31000 сайн дурын эрүүл хүмүүс оролцсон ба судалгаанд суурь өвчинтэй тухайлбал, астма, зүрх судас, бөөрний өвчтэй болон хавдартай өвчтнүүдийг оруулаагүй байна. Арабын Нэгдсэн Эмират улсын эрүүл мэндийн удирдлагаас эхний тунгаа хийлгэхийн өмнө сүүлийн 14 хоногт халуурах, хуурай ханиалгах, хамар битүүрэх, ядарч сульдах шинж илэрсэн, хөхүүл, жирэмсэн, дархлаа дарангуйлагдах өвчтэй, ямар нэгэн харшилтай болон 3 сарын дотор жирэмсэн болох төлөвлөгөөтэй бол тэдгээр хүмүүсийг вакцинд хамрагдахгүй байх зөвлөмжийг гаргасан байна. Мөн 21 хоногийн дараа 2 дахь тунг хийхийг зөвлөсөн байна. Синофарм вакцины 1, 2-р шатанд 18-80 насны 192 (1-р шат), 448 (2-р шат) эрүүл хүмүүс оролцсон ба тэдэнд ямар нэгэн онц гаж нөлөө илрээгүй байна. Синофарм вакциныг энгийн хөргөгчний нөхцөлд тээвэрлэх, хадгалах боломжтой. Pfizer-BioNTech болон Модерна вакцинаас ялгаатай нь Синофарм (BBIBP-CorV) вакцины аюулгүй байдал болон хамгаалах чадварыг харуулсан судалгаа олон нийтэд хүрээгүй, үр дүнг боловсруулах шатыг хянан тохируулсан эсэхийг тодорхой мэдээлээгүй байна. Синофарм компаний удирдлагууд судалгаа дуусмагц судалгааныхаа дэлгэрэнгүй үр дүнг олон улсын шинжлэх ухааны сэтгүүлд нийтлүүлнэ хэмээн 12 сарын 31-нд мэдэгдсэн байна.

Эх сурвалж:

1. <https://gulfnnews.com/special-reports/sinopharm-covid-19-vaccine-all-you-need-to-know-1.1613923087408>
2. <https://gulfnnews.com/uae/health/uae-ministry-of-health-announces-86-per-cent-vaccine-efficacy-1.1607490555571>
3. <https://www.reuters.com/article/us-health-coronavirus-vaccine-china-idUSKBN29505P>
4. <https://www.just.edu.io/DIC/Manuals/COVID-19%20%20Vaccines.pdf>

#### 4. Спутник вакцины тухай товч тойм

Спутник (Gam-COVID-Vac) вакцин нь Оросын Гамалей судалгааны институтийн боловсруулсан вакцин юм. Вакцины дархлаа тогтоох чадвар нь 91.6% байсан бөгөөд 3-р шатны судалгаанд 18-аас дээш насны нийт 40000 эрүүл хүмүүс болон ямар нэгэн архаг суурь өвчтэй хүмүүс оролцсон байна. Тухайлбал, нийт вакцин хийлгэсэн хүмүүсийн 24.7% нь чихрийн шижин, даралт ихсэлт, зүрхний ишеми, таргалалттай хүмүүс байжээ. Ерөнхий шинж тэмдгүүд болох ядарч сульдах, халуурах тохиолдол маш ховор байсан ба вакцины 2-дахь тунг 21 хоногийн дараа хийхийг зөвлөсөн байна. Вакциныг ердийн хэмд хадгалж болно. Судалгаанд жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, дархлаа дарангуйлагдсан, титэм судасны цочмог хам шинжтэй болон харвалтын өгүүлэмжтэй хүмүүс ороогүй байна.

Эх сурвалж:

1. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7852454/>
2. <https://www.telegraph.co.uk/global-health/science-and-disease/sputnik-vaccine-side-effects-efficacy-russian-covid-jab-safe/>
3. <https://www.bbc.com/news/health-55900622>

## 5. Модерна вакцины тухай товч тойм

Модерна (*mRNA-1273*) COVID-19 вакцин нь АНУ-ын Харшил, халдварт өвчний төв, Био-анагаах ухааны судалгаа, хөгжүүлэлтийн удирдлага болон Модерна компаниудын гарган авсан PHX төрлийн вакцин бөгөөд Монгол улсад одоогоор хэрэглэгдээгүй байгаа ч 2021 оны 1 сарын 10-ны өдрийн Дархлаажуулалтын Үндэсний хороо, Хүний эмийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэсэн байна. Энэхүү вакциныг Америкийн Хүнс, эмийн агентлаг (FDA)-аас яаралтай хэрэглэх горимоор 0.5 мл тунгаар 4 долоо хоногийн зайтай хэрэглэхийг зөвшөөрсөн байна. Модерна вакцины хамгаалах чадварын тухайд эхний тунг хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дараа дархлаа тогтож эхэлж байсан ба 2 дахь тунгаа хийлгэснээс 2 долоо хоногийн дараа 94,1%-ийн дархлаа тогтож байсан байна. Судалгааг зөвхөн 18-аас дээш насны эрүүл хүмүүсийн дунд хийсэн ба одоогоор 0-11 насны хүүхдүүдэд зориулсан KidCOVE болон 12-17 насны хүүхдүүдэд зориулсан TeenCOVE вакцинуудын туршилтыг эхлүүлээд байна. Вакцины 3-р шатны судалгаанд архаг хууч өвчтэй хүмүүсийг хамруулсан бөгөөд судалгааны үр дүнд дархлаа тогтох чадвар бүх хүмүүст адилхан байсан. Гэвч судалгаанд жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг хамруулаагүй бөгөөд тэдгээрт вакцин ямар нэгэн гаж нөлөө байгаа эсэх нь тодорхойгүй байна. Модерна (*mRNA-1273*) вакцины аюулгүй байдлын тухайд ДЭМБ-аас олон нийтэд хэрэглэх зөвшөөрөл олгосон бөгөөд ямар нэгэн өвөрмөц гаж нөлөөгүй гэдгийг нь баталгаажуулсан байна. Түгээмэл илрэх урвалууд нь тарьсан газар өвдөх, ядарч сульдах, толгой өвдөх, үе мөч болон булчигаар өвдөх ба эдгээр урвалууд нийт судалгаанд оролцогчдын 0.2-9.7%-д нь л илэрсэн байна. Өвөрмөц тохиолдож болох сөрөг урвалуудаас лимфоаденопати (1.1%), бэллийн палси (<0.1%) болон хэт мэдрэгшилтэй холбоотой урвалууд (1.5%) тухайлбал, тарьсан газар улайх, тууралт гарах шинж илэрч болно. Мөн эдгээр ерөнхий урвалууд 65-аас дээш насны хүмүүст илүү бага байгааг ДЭМБ тэмдэглэсэн байна. Америкийн Хүнс, эмийн агентлаг (FDA)-аас анафилаксийн урвалыг 2,5 саяд нэг тохиолдол гэж тэмдэглэсэн ба мөн тарьсан газар хавдах, харшлын улайлт маш ховор гэж бүртгэжээ. Вакциныг хадгалах нөхцөл нь +2°C-оос +8°C хэмд 30 хоног хүртэл эсвэл -20°C хэмд 4 сар

хүртэл хадгалах боломжтой гэж тус вакциныг үйлдвэрлэгч Модерна компани мэдэгдсэн байна.

Эх сурвалж:

1. <https://montsame.mn/mn/read/249416>
2. <https://www.cdc.gov/vaccines/covid-19/info-by-product/moderna/index.html#:~:text=Persons%20age%2018%20years%20and,the%20recommended%20interval%20as%20possible.>
3. [https://www.who.int/publications/i/item/background-document-on-the-mrna-1273-vaccine-\(moderna\)-against-covid-19](https://www.who.int/publications/i/item/background-document-on-the-mrna-1273-vaccine-(moderna)-against-covid-19)
4. <https://www.aappublications.org/news/2021/03/16/moderna-covid-trials-children-031621>
5. <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/vaccines/recommendations/pregnancy.html>

### **Зүрх судасны өвчтэй хүнд илүү тохиромжтой вакцин**

Одоогийн байгаа мэдээллээр вакцины туршилтанд хамгийн их зүрх судасны өвчтэй иргэдийг хамруулж, тэдний аюулгүй байдал, дархлаа тогтоох чадварыг судалсан нь Pfizer-BioNTech (BNT162b2) вакцин байна. Судалгаанд оролцогсдын дунд артерийн даралт ихсэх өвчин 24.5% чихрийн шижин 8.4%, уушгины архаг бөглөрөлт өвчин 7.8%, зүрхний шигдээстэй өвчтөн 1% орчим байсан ба үр дүн нь эрүүл хүмүүстэй адил байжээ. Гэвч судалгаанд өвчин хүндрээгүй буюу ээнэгшилээ алдаагүй иргэдийг хамруулсан тул өвчин сэдэрсэн болон хүндэрсэн өвчтөнүүдэд вакцин ямар үр дагавартай эсэх нь тодорхойгүй байна.



### Жирэмсэн эмэгтэйчүүдэд илүү тохиромжтой вакцин

Америкийн эрдэмтдийн судалгаагаар Pfizer-BioNTech (BNT162b2) болон Модерна (mRNA-1273) вакциныг 131 жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд хийхэд бусад эмэгтэйчүүдтэй адил дархлаа тогтоож байсан ба гаж нөлөө илрээгүй байна. Мөн эхэд үүссэн эсрэгбие ихэс болон сүүгээр дамжин нярайд дархлаа тогтоосныг тэмдэглэжээ. Гэсэн хэдий ч судлаачид судалгаанд оролцогчдын тоо маш бага байсан учраас судалгааг үргэлжлүүлэн хийх хэрэгтэй гэж дүгнэжээ. ДЭМБ жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд ямар нэгэн гаж нөлөө байж болох нотолгоо байхгүй учраас халдвар авах өндөр эсдэлтэй эсвэл архаг өвчтэй эмэгтэйчүүдэд эдгээр вакциныг хийхийг зөвлөсөн байна.


Эх сурвалж:

1. [https://www.ajog.org/article/S0002-9378\(21\)00187-3/fulltext](https://www.ajog.org/article/S0002-9378(21)00187-3/fulltext)
2. <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/vaccines/recommendations/pregnancy.html#:~:text=There%20is%20current%20no%20evidence,receiving%20a%20COVID%2D19%20vaccine.>
3. <https://theconversation.com/covid-19-vaccines-are-highly-effective-for-pregnant-women-and-their-babies-new-study-157930>

## ХОЁР. ВАКЦИНЫ ҮЙЛЧЛЭЛИЙН ТАЛААР ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

ДЭМБ-ын 2021.04.22-ны өдрийн мэдээллээр Ковид-19-ийн халдварын вакцины клиник туршилтын 38, эрсдэлт хүчин зүйлсийн 38, оношилгооны 33, нийгмийн эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйлсийн 32, ёс зүйн 21, тэгш ба тэгш бус байдлын 11, эрүүл мэндийн эдийн засгийн 3, нийт 491 вакцины талаарх судалгааны ажлууд хийгдэж, судалгааны үр дүнгээр “Nature” сэтгүүлд 40, “Vaccine” сэтгүүлд 30, “Science” сэтгүүлд 29, “Lancet” сэтгүүлд 22 өгүүлэл тус тус хэвлэгдсэн байна.

2021 оны 4 сарын 21-ны байдлаар нийт 110 вакцин бүртгүүлэхээр нэр дэвшиж, 312 вакцин туршилтанд, 14 вакцин ДЭМБ болон олон улсад бүртгэгдээд байна. Түүнчлэн 184 вакцин лабораторийн болон амьтны туршилт хийгдэх эмнэлзүйн өмнөх шатанд байгаа ба эрүүл, залуу хүмүүсийг хамруулсан эмнэлзүйн 1-р шатны туршилтанд 31 вакцин, хүмүүсийг өргөн хүрээгээр хамруулсан 2-р шатны туршилтанд 33 вакцин, олон улсын хэмжээнд 3-р шатны туршилтанд 23 вакцин, нийт хүн амын хэрэглээнд санал болгож байгаа 13 вакцин, батлагдсаны дараа илүү олон хүн амыг хамруулах 4-р шатны туршилтанд 4 вакцин судлагдаж байна.



Эх сурвалж:

<https://covid19.trackvaccines.org/>

Эмнэлзүйн туршилтын шатандаа явагдаж буй вакцинууд нь өөр хоорондоо ялгаатай бөгөөд вирусын уургийн вакцин 18, вирусын векторт суурилсан (өөрийгөө олшруулах чадамжгүй) 9, ДНХ-д суурилсан 8, идэвхгүйжүүлсэн вакцин 8, РНХ-д суурилсан 8 болон бусад платформуудад 10 вакцин тус тус хийгдэж, судлагдаж байна.

Эх сурвалж:

<https://www.who.int/publications/m/item/fair-allocation-mechanism-for-covid-19-vaccines-through-the-covax-facility>

## 1. Францын хүн амын дундах КОВИД-19 вакцины талаарх эргэлзээ

Энэхүү туршилт судалгаанд SARS-CoV-2 дархлаажуулалтад хамрагдсан, Франц Улсын насанд хүрсэн хүн амыг төлөөлөх чадвар бүхий 18-64 насны хүмүүсийг санамсаргүй, цахим түүвэрлэлтын аргаар сонгон оролцуулж, хүйс, нас, боловсролын түвшин, ам бүлийн тоо, бүс нутаг, оршин суугаа орон нутгийн байршлаар бүлэглэн судалсан байна. Судалгааны асуумжийг хөдөлмөрийн насны 1942 насанд хүрэгчдээс авсан бөгөөд тэдгээрийн 560 хүн (28.8%) вакцин хийлгэхээс шууд татгалзсан, харин 1382 хүн (71.2%) шууд татгалзаагүй байна.

Судалгааны үр дүнд вакцинаас шууд татгалзах нь КОВИД-19-ийн хүнд хэлбэрээр өвчлөөгүй байдалтай холбоотой байсан бол нийтийн дархлааны үр ашгийн талаар мэдээлэл харилцааг өрнүүлсэн тохиолдолд вакцинд эргэлзэх байдал харьцангуй бага, мөн хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн дунд ажил хийдэггүй хүмүүсээс бага байна. Түүнчлэн КОВИД-19 халдвараар өөрөө эсвэл өвчилж байсан хэн нэгнийг мэддэг хүмүүсийн дунд вакцинд эргэлзэх байдал харьцангуй бага байв.

Вакцинд эргэлзэх хандлага “хятадад үйлдвэрлэсэн”, “дархлаа тогтоох үр дүн 50%”, “хүнд хэлбэрийн хариу урвалын тохиолдол 10,000-д 1” гэсэн тохиолдлуудад хамгийн өндөр (вакциныг хүлээн зөвшөөрсөн 27.4%, 95% CI 26.8-28.0) байв.

Харин вакциныг “Европод үйлдвэрлэсэн”, “дархлаа тогтох үр дүн 90%”, “хүнд хэлбэрийн хариу урвалын тохиолдол 100,000-д 1” байгаа тохиолдолд вакцинд эргэлзэх байдал хамгийн бага байв (вакциныг хүлээн зөвшөөрсөн 61.3%, 95% CI 60.5-62.1).

КОВИД-19 вакциныг хүлээн зөвшөөрөх байдал нь Францын хөдөлмөрийн насны хүн амын дунд тухайн шинэ вакцины шинж чанар, дархлаажуулалтын үндэсний стратеги зэргээс хамаарч байна. Дархлаажуулалтын үндэсний стратегийн тэргүүлэх байр суурь нь насанд хүрсэн нийт хүн амд нийтийн дархлаа тогтоохоос илүүтэйгээр өндөр настай хүмүүсийг өөрийгөө хамгаалахад чиглэвэл илүү үр дүнтэй байна. Дархлаажуулалтын үндэсний стратегийн зорилго нь нийтийн дархлаа тогтоох эсэхээс үл хамааран Европд үйлдвэрлэсэн КОВИД-19 вакциныг ашиглахын зэрэгцээ, хөдөлмөрийн насны хүн амын дунд нийтийн дархлаа тогтоохын ач тусыг сурталчлах мэдээлэл харилцааг өрнүүлэх нь илүү үр дүнтэй байхаар байна.

Эх сурвалж:

[Michaël Schwarzinger, Verity Watson, Pierre Arwidson, François Alla, Stéphane Luchini., The McGill University COVID19 Vaccine Tracker., Lancet Public Health., 2021; 6: e210–21, Published Online February 5, 2021](#)

## 2. Вакцин ба вирусн шинэ төрлүүд

Сүүлийн хэдэн сарын хугацаанд SARS-CoV-2-ийн эсрэг вакцины өндөр үр дүнг харуулсан 3-р шатны олон судалгааны үр дүнгүүд гарч, үүний дараа хэд хэдэн вакциныг хурдан хугацаанд зөвшөөрөн батлаж, хэрэглээнд нэвтрүүлсэн нь итгэл найдварыг нэмэгдүүлж байсан. Гэсэн хэдий ч вакцинаар үүсгэгдсэн эсрэгбиетэд мэдрэг чанар бага, дамжих чадвар өндөр вирусн хэд хэдэн шинэ хувилбарууд гарч ирсэн нь энэхүү итгэлийг унагаж байна. Шинээр гарч ирж буй мутацид орсон SARS-CoV-2-ийн төрлүүд нь вакцины үр нөлөөнд нөлөөлж байгааг судлаачид тогтоосон байна. Тухайлбал: Их Британи улсын Астра-Зенека (AZD1222, ChAdOx1 nCoV-19, Covishield, Vaxzevria) вакциныг вирусн халдварын шинж тэмдэг бүхий батлагдсан

КОВИД-19-ийн эсрэг 70,4% -ийн үр дүнтэй гэж өмнө нь мэдээлж байсан. 18 ба түүнээс дээш насны 8534 хүний бүлгээс (18-55 насны 6636 [78%], 5065 [59%] эмэгтэй, 7863 [92%] Цагаан) ChAdOx1 nCoV-19 вакцин болон хяналтын менингококкийн конъюгат вакцин хийлгэснээс хойш 14 хоногоос дээш хугацаанд SARS-CoV-2-ийн халдварт эерэг үр дүнтэй байсан 311 оролцогчдод дүн шинжилгээ хийсэн байна.

Шинж тэмдэг бүхий халдварын эсрэг вакцины үр дүн В.1.1.7 хувилбарын хувьд 70,4% (95% CI 43,6 – 84,5), бусад хувилбаруудад 81,5% (67,9 – 89,4) байв. Судалгааны дүнд вакцин нь В.1.1.7 хувилбарын эсрэг саармагжуулах идэвхжил нь вакцинд хамрагдсан иргэдийн сийвэнгийн дээжинд бусад төрлүүдтэй харьцуулахад 9 дахин буурсантай тэнцэхүйц байсан бөгөөд энэ нь вакцины шинэ хувилбарт үр дүн багатай болохыг нь харуулж байна.

Вакцины үр нөлөө буурсан байж болзошгүй талаар хамгийн их санаа зовоож байгаа асуудал нь В.1.1.7.1-аас бусад Бразил, Өмнөд Африкаас гаралтай Р.1 ба В.1.351 омгуудад агуулагдах огцом мутацид орсон Glu484Lys ба бусад хэд хэдэн шинээр эргэлтэд гарч эхэлж буй хувилбарууд юм. Учир нь, тус судалгааны үеэр эдгээр хувилбарууд нь Их Британид хараахан өргөн тархаагүй байсан тул дэлгэрэнгүй шинжлэгдээгүй болно. Glu484Lys мутаци нь вакцин эсвэл өөр хувилбарын бус вирусын халдвар авсан хүмүүсийн моноклон эсрэгбиеийн саармагжуулах идэвхийг ихээхэн бууруулж байна. ChAdOx1 nCoV-19 вакцин нь Өмнөд Африкт 2-р шатны туршилтанд бага үр дүнтэй байсан учир нь тус бүсэд В.1.351 хувилбарууд давамгайлж байна. Энэ нь Glu484Lys агуулсан хувилбарууд эргэлтэнд гарч, давамгайлах үед вакцины үр нөлөөг цаашид бууруулж болзошгүйг харуулж байна. Хамгийн чухал нь Glu484Lys мутацийг агуулсан В.1.1.7 дэд хувилбарууд нь Их Британи болон бусад газарт бий болж эхлээд байна.

Эх сурвалж:

[Rogier W Sanders, Menno D de Jong., Pandemic moves and countermoves: vaccines and viral variants, The Lancet Journal., March 30, 2021](#)

### 3. ДЭМБ-ын Газар дундын тэнгис, зүүн бүс нутгууд дахь КОВИД-19 халдварын дахин сэргэлт

Долоон 7 хоногийн туршид буурах үзүүлэлттэй байсан КОВИД-19-ийн тохиолдол нь 2021 оны 2-р сарын 22-ны долоо хоногт дэлхий дахинаа огцом өсөлт үзүүлэв. Энэхүү өсөлт нь ДЭМБ-ын Газар дундын тэнгис, зүүн бүсэд ихээхэн ажиглагдсан бөгөөд 2021 оны 1-р сарын 30-наас 2-р сарын 26-ны хооронд долоо хоногт тохиолдлын тоо 158004-ээс 207424 болж нэмэгдсэн (31%). Энэ өсөлтөд олон хүчин зүйл нөлөөлсөн байж болзошгүй ба шинжилгээний чадамж, стратегийн өөрчлөлт, олон нийтийн цугларалттай холбоотой халдварын тархалт нэмэгдэх, нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг дагаж мөрдөх байдал буурсан зэрэг хүчин зүйлс орно. КОВИД-19 -ийн тохиолдол нэмэгдэж байгаа нь сэтгэл түгшээж байгаа бөгөөд Газар дундын тэнгис, зүүн бүсэд вакцины үр нөлөө ойрын хэдэн сар ажиглагдахгүй байх магадлалтай байгааг тогтоожээ. Тиймээс SARS-CoV-2-ийн тархалтыг ДЭМБ, түүний гишүүн орнууд ба түншүүдийн хооронд хамтын ажиллагааг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоо, нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний цогц зохион байгуулалтыг хийж, өвчтнүүдийг хурдан илрүүлж, халдварын хавьталын (ялангуяа шинэ төрлийн вирусын хувилбарууд) системчилсэн мөрдөлт, хорио цээрийн дэглэмийг хатуу чанд мөрдсөнөөр хумьж чадна.

Эх сурвалж:

Pierre Nabeth, Mahmoud Hassan, Keyrellous Adib, Abdinasir Abubakar, Richard Brennan., New COVID-19 resurgence in the WHO Eastern Mediterranean region., The Lancet Journal., March 25, 2021

## ГУРАВ. КОВИД 19-ИЙН ВАКЦИНЫ ГАЖ НӨЛӨӨ

ДЭМБ-ын баталгаатай эх сурвалжаас КОВИД 19 халдварын эсрэг вакцин хийлгэсний дараа “Ядрах, халуурах, толгой өвдөх, бие өвдөх, бие жихүүцэх, дотор муухайрах, гүйлгэх болон тариулсан хэсэгт хөндүүрлэх зэрэг хариу урвал үзүүлж байна” гэжээ. Хүн бүрт хариу урвал харилцан адилгүй илрэх бөгөөд зарим хүнд огт мэдэгдэхгүй байхад заримд нь хүчтэй илэрдэг. Хариу урвал илрэлийн зэрэг нь биеийн дархлааны түвшинтэй хамааралгүй юм. Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн төв (CDC)-ийн баталгаатай сурвалжид мэдэгдсэнээр дараах зөвлөмжүүдийг өгч байна.

### Зөвлөмж

- Вакцинжуулалтад хамрагдахаас өмнө ямар нэгэн эм хэрэглэх хэрэггүй.
- Хариу урвал илрэх эсэхийг ажиглаж, хэрвээ зовиур илэрвэл хяналтын эмчдээ мэдэгдэж, биеийн байдал, өвчний түүхээ хянуулсаны дараагаар эм хэрэглэх хэрэгтэй.
- Яаралтай үед эсвэл эмчээс зөвлөгөө авах боломжгүй үед ибупрофен, парацетамол, аспирин ууж болно.
- Тариулсан хэсгийн өвдөлтийг намдаахын тулд цэвэрхэн, чийгтэй алчуураар жин тавьж болно.
- Гараа бага багаар хөдөлгөснөөр булчингийн чангарлыг суллаж өвдөлтийг намдаахад тустай.
- Гэртээ хэт их зузаан хувцаслаж болохгүй бөгөөд шингэн зүйл сайн уух хэрэгтэй.
- Moderna вакцин хийлгэсний дараа гаран дээр улаан өнгийн тууралт гарах тохиолдол илэрч байгаа бөгөөд энэ нь тийм ч ноцтой зүйл биш юм.

### Вакцины хариу урвал хэр удаан үргэлжлэх вэ?

- Цөөн хэд хоногт илэрнэ.
- Хэрэв удаан хугацаагаар үргэлжлэх эсвэл зовиур маш хүчтэй илэрвэл эмчид хандах хэрэгтэй.
- Вакцин хийлгэсний дараах эхний 14 хоногт халдвар авах эрсдэлтэй учраас өвчний шинж тэмдэгтэй төстэй зовиур илэрвэл шинжилгээ өгч, дараагийн арга хэмжээг авах шаардлагатай.
- Вакцин хийлгэсний дараа анафилаксийн шоконд орох магадлал 1 саяд 2-5 тохиолдол байна хэмээн үзсэн байна.

Эх сурвалж:

[Medicalnewstoday.com](https://www.medicalnewstoday.com) - Written by Audrey Amos, Pharm.D. on May 18, 2021 — Fact checked by Lindsay Slowiczek, Pharm.D.

Биологийн бүтээгдэхүүний Бээжингийн хүрээлэнгээс хөгжүүлсэн **СИНОФАРМ** вакцин нь ДЭМБ-аас яаралтай үед хэрэглэх зөвшөөрөл авсан Хятад улсын анхны вакцин юм. Хятадын үндэсний эмийн бүтээгдэхүүний захиргаанаас 2020 оны 12-р сарын 31-ны өдөр зөвшөөрөл авч, ДЭМБ-ын яаралтай үед хэрэглэх зөвшөөрөлтэй вакцины жагсаалтад 2021 оны 5-р сарын 07-ны өдөр бүртгэгдсэн байна. Синофарм вакцины нийтлэг хариу урвал нь:

- Толгой өвдөх
- Ядрах
- Тариулсан хэсэгт өвдөх явдал байна.

Одоогийн байдлаар дэлхийн 42 гаруй улс синофарм вакциныг хэрэглэхийг зөвшөөрсөн байна.



Синофарм вакциныг уламжлалт технологиор хийсэн ба идэвхгүйжүүлсэн вирус агуулсан 2 тунтай бөгөөд вирусыг  $\beta$  – продиолактон химийн бодисоор үйлчлүүлсэн. Энэ химийн бодис нь вирусын генетик материалтай холбогдож репликаци явуулах чадварыг зогсоох үйлчилгээтэй юм. Хөнгөн цагааны гидроксидыг вакцины адъювант болгож ашигласан. Энэ нь вакцины эсрэг дархлааг сайжруулахад ач холбогдолтой.

ДЭМБ -аас Синофарм вакциныг 18-аас дээш насны хүн хийлгэх бөгөөд эхний тунг хийлгэсний дараа 3-4 долоо хоногийн дараа 2 дахь тунг хийлгэхийг зөвлөж байна. ДЭМБ -аас 3 шатны клиник туршилтын аюулгүй байдлыг синофарм вакцин хийлгэсэн 16671 оролцогчийн мэдээлэлд хяналт хийж үзсэн байна. Вакцин хийлгэсний дараа илэрч болох 2 ноцтой хариу урвалыг ДЭМБ тодорхойлсон байна. Үүнд:

- Дотор муухайрах зовиур хүнд хэлбэрээр илрэх
- Ховор төрлийн мэдрэлийн гаралтай өвчин /цочмог тархалттай энцефалит/

Мөн цусны бүлэгнэлт үүсэх тохиолдол гарсан байна. Хятадад 65 -аас дээш насны 1.1 сая хүнд синофарм вакциныг хийхэд толгой эргэх, толгой өвдөх, ядрах, дотор муухайрах, халуурах, бөөлжих, харшил өгөх зэрэг хариу урвал илэрчээ. Ноцтой хариу урвал илрээгүй ч 65-аас дээш насны хүмүүсийн талаарх судалгааны мэдээлэл дутмаг байгаа байдлыг анхаарах нь зүйтэй гэж ДЭМБ онцолжээ.

Эх сурвалж:

[Medicalnewstoday.com](https://www.medicalnewstoday.com) - Written by Harriet Pike, Ph.D. on May 18, 2021 — Fact checked by Yella Hewings-Martin, Ph.D.

БНХАУ-ын **Синофарм** үйлдвэрийн BBIBP-CorV Ковид-19-ийн вакцинд ДЭМБ-ын дэргэдэх Дархлаажуулалтын Стратегийн Зөвлөх Мэргэжилтнүүдийн Бүлэг (Strategic Advisory Group Of Experts (SAGE)) үнэлгээ хийжээ. Ажлын хэсгээс дараахь 4 асуудлыг тусгайлан авч үзсэн байна.

Үүнд:

- Насанд хүрэгчдэд (18-59 нас) вакцины үр ашиг болон аюулгүй байдлын баталгаа ямар байна вэ?
- Ахмад настны бүлгүүдэд ( $\geq 60$  нас) ашиглахад баталгаа ямар байна вэ?
- Зарим хавсарсан өвчин болон эрүүл мэндийн эмзэг төлөв байдлын үед аюулгүй байдал, вакцины үр нөлөөний баталгаа ямар байна вэ?
- Зөвлөмж, Үнэлгээ, Боловсруулалт, Дүгнэлт (Grading of Recommendations, Assessment, Development and Evaluation-GRADE)-ээр баримтын үнэлгээ хийх

Эмнэлзүйн туршилтын 1-р, 2-р шат БНХАУ-д хийгдсэн, 3-р шат БНХАУ болон Арабын Нэгдсэн Эмират Улс, Бахрайн, Египт, Йордан улсуудад хийгдсэн байна.

**Хүснэгт 1.** 3-р шатанд вакцины үр нөлөөг олон оронд туршсан үр дүн  
(дундаж хугацаа 112 хоног)

Бүлэг/Дэд бүлэг	BBIBP-CorV бүлэг		Плацебо бүлэг		Вакцины үр ашиг % (95% CI)
	Эрсдлийн тоо	Тохиолдлын тоо	Эрсдлийн тоо	Тохиолдлын тоо	
Overall/ Ерөнхий	13765	21	13765	95	78.1 (64.9, 86.3)
Hospitalization /Эмнэлэгт эмчлүүлсэн	13765	3	13765	14	78.7 (26.0, 93.9)
Severe/ Хүндрэл	13765	0	13765	2	NE

Хүйс					
Эрэгтэй	11598	18	11642	83	78.4 (64.1, 87.0)
Эмэгтэй	2167	2	2123	13	75.6 (13.3, 93.1)
Насны бүлэг					
18-59 нас	13,556	21	13,559	95	78.1 (64.9, 86.3)
≥60 нас	209	0	206	0	NE
Хавсарсан өвчин					
Цусны даралт ихдэлт	374	0	367	4	NE
Чихрийн шижин	300	2	308	6	63.7 (-79.8, 92.7)
Таргалалт	3,040	7	3,080	36	80.7 (56.7, 91.4)

NE=тооцоолоогүй

**Хүснэгт 2.** Дархлаажуулалтын стратегийн зөвлөх мэргэжилтнүүдийн бүлгийн үнэлгээ

Өгөгдөл	Баримтын чанарын талаарх мэдэгдэл	Дархлаажуулалтын Стратегийн Зөвлөх Мэргэжилтнүүдийн Бүлэг-ийн дүгнэлт
PCR шинжилгээгээр Ковид -19 батлагдсан тохиолдолд вакцины үр дүн (насанд хүрэгчдэд)	Өндөр итгэлтэй	Насанд хүрэгчдэд (18-59 нас) BBiBP-CoV-ийн 2 тун нь PCR шинжилгээгээр Ковид-19 батлагдсан тохиолдолд дахин халдвар авахаас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй гэдэгт бид өндөр итгэлтэй байна
Аюулгүй байдлын сөрөг нөлөө (насанд хүрэгчдэд)	Дунд зэргийн итгэлтэй	Насанд хүрэгчдэд (18-59 нас) BBiBP-CoV-ийг 1-2 тунгаар хэрэглэсний дараа ноцтой сөрөг үзэгдлүүд гарах эрсдэл бага гэдэгт бид дунд зэрэг итгэлтэй байна.
PCR шинжилгээгээр Ковид-19 батлагдсан тохиолдолд вакцины үр дүн (ахмад настанд)	Бага итгэлтэй	BBiBP-CoV-ийн 2 тун ахмад насны хүмүүст (≥60 нас) PCR шинжилгээгээр Ковид -19 батлагдсан тохиолдолд дахин халдвар авхаас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй гэдэгт бага итгэлтэй байна

Аюулгүй байдлын сөрөг нөлөө (ахмад настан)	Маш бага итгэлтэй	BBIBP-CorV-ийг 1-2 тунгаар хэрэглэсний дараа ахмад насны хүмүүст ( $\geq 60$ нас) ноцтой сөрөг үр дагавар үзүүлэхгүй гэдэгт итгэх итгэл маш бага байна
PCR шинжилгээгээр Ковид-19 батлагдсан тохиолдолд вакцины үр нөлөө (хавсарсан өвчтэй болон эрүүл мэндийн тодорхой нөхцөл байдалтай хүмүүс)	Маш бага итгэлтэй	BBIBP-CorV-ийн 2 тун нь PCR шинжилгээгээр Ковид-19 халдвар батлагдсан, хүндрэх эрсдэлтэй, хүнд хэлбэрийн хавсарсан өвчтэй болон эрүүл мэндийн тодорхой нөхцөл байдалтай хүмүүст дахин халдвар авахаас урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй гэдэгт бид маш бага итгэлтэй байна
Аюулгүй байдлын сөрөг нөлөө ( хавсарсан өвчтэй болон эрүүл мэндийн тодорхой нөхцөл байдалтай хүмүүс)	Маш бага итгэлтэй байна	BBIBP-CorV-ийн 1-2 тунг хэрэглэсний дараа Ковид-19-ийн халдвар хүндрэх эрсдэлтэй, хүнд хэлбэрийн хавсарсан өвчтэй болон эрүүл мэндийн тодорхой нөхцөл байдалтай хүмүүст тохиолдох ноцтой сөрөг үр дагаварын эрсдэл бага гэдэгт бид маш бага итгэлтэй байна

Тус үнэлгээгээр ахмад насны бүлэгт ( $\geq 60$  нас) сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар туршилтын үр дүн хангалттай их биш байгаа боловч энэ нь яаралтай горимд хэрэглэх зөвшөөрөл олгоход саад болохгүй бөгөөд цаашид үргэлжлүүлэн судлах боломжтой гэж үзжээ.

Эх сурвалж:

[https://cdn.who.int/media/docs/default-source/immunization/sage/2021/april/2\\_sage29apr2021\\_critical-evidence\\_sinopharm.pdf?sfvrsn=3dfe32c1\\_5&fbclid=IwAR2cB5VArpstYsh\\_MZRJ5yw1bkwFXddeZH0vseCd-XiFLSmWOYszkABeT24](https://cdn.who.int/media/docs/default-source/immunization/sage/2021/april/2_sage29apr2021_critical-evidence_sinopharm.pdf?sfvrsn=3dfe32c1_5&fbclid=IwAR2cB5VArpstYsh_MZRJ5yw1bkwFXddeZH0vseCd-XiFLSmWOYszkABeT24)

ОХУ -ын хөгжүүлж гаргасан **СПУТНИК V** (ГАМ – КОВИД – ВАК) вакциныг дэлхийн 64 улс оронд хүлээн зөвшөөрөн хэрэглэж байна. Одоо тус вакциныг Европын холбоо - Европын эмийн агентлагаар шалгуулж байгаа юм.

**СПУТНИК V** нь 2 төрлийн аденовирусын вектор агуулсан вакцин бөгөөд 91.6% үр дүнтэй. Вакцины 2 тун аденовирусын өөр өөр векторийг агуулдаг бөгөөд 2 өөр вектор ашиглах нь илүү өндөр үр дүнтэй эсрэгбие үүсгэдэг болохыг судалгаагаар тогтоосон байна.

- Эхний тун – Аденовирус 26 вектор
- Хоёр дахь тун – Аденовирус 5 вектор

**СПУТНИК V** вакцины нийтлэг илрэх гаж нөлөө:

- Ханиадтай төстэй шинж тэмдэг илрэх
- Толгой өвдөх
- Ядрах
- Вакцин тарьсан газар хөндүүрлэх

Аденовирус нь байгалийн жамаар биед орсоны дараа репликаци буюу үржиж олшрон, амьсгалын замын халдварыг үүсгэдэг. Харин вакцинд ашиглахдаа репликаци явуулах чадварыг байхгүй болгож өөрчилдөг. СПУТНИК V вакцины хувьд репликацийн процессыг явуулдаг E1 генийн хэсгийг байхгүй болгосон байна.

Эх сурвалж:

[Medicalnewstoday.com](https://www.medicalnewstoday.com) - Written by Minseo Jeong on May 10, 2021

Катар улс 2020 оны 12-р сарын 21-ны өдрөөс **Pfizer–BioNTech** (BNT162b2) вакцинаар Ковид-19-ийн эсрэг дархлаажуулалтын хөтөлбөрийг эхлүүлсэн. Судалгаагаар Pfizer-BioNTech вакцин нь вирусын шинэ хоёр хувилбар болох В.1.1.7 болон В.1.351-ийн эсрэг өндөр үр дүнтэй байгааг тогтоосон байна. 2021 оны 2-р сарын 23-аас 3-р сарын 18-ны хооронд явуулсан вирусын геномын дараалал тогтоох шинжилгээгээр Катар дахь Ковид-19-ийн халдварын 50.0% -ийг В.1.351, 44.5% -ийг В.1.1.7 вирусээс үүдсэн болохыг тогтоожээ. 3-р сарын 7-ноос хойш вирусын дараалал тогтоосон бараг бүх тохиолдол В.1.351 эсвэл В.1.1.7-ийн аль нэгнийх нь улмаас үүссэн байна.

Уг судалгаа нь Катарын үндэсний мэдээллийн сангаас авсан хэдэн зуун мянган иргэдийн мэдээлэлд үндэслэсэн тооцоо бөгөөд Pfizer-BioNTech вакцин нь хоёр дахь тунгаас хойш 14 ба түүнээс дээш хоногийн дараа В.1.1.7-ийн халдварын эсрэг 89.5% -ийн үр дүнтэй В.1.351-ийн халдварын эсрэг 75%-ийн үр дүнтэй болохыг харуулж байна.

Харин Катар улсад 3-р сарын 31-ний байдлаар вакцины нэг тунг хийлгэсэн 6689 хүнд, хоёр тунг хийлгэсэн 1616 хүнд халдвар бүртгэгдсэн байна. Вакцин хийлгэсэн хүмүүсийн дунд нас барсан тохиолдол 7 бүртгэгдсэн байна. Үүнээс эхний тунг хийлгэсний дараа 5, хоёр дахь тунг хийлгэсний дараа 2 бүртгэгджээ. Гэсэн хэдий ч Ковид-19-ийн халдварын улмаас хүндрэх эрсдэлтэй, үхэлд хүргэх аюултай хүнд өвчтэй хүмүүст вакцины үр нөлөө маш өндөр буюу 90%-иас дээш үр дүнтэй гарсан байна.

Судалгааны үр дүнг батлах зорилгоор хоёр дахь судалгааг явуулсан ба энэ нь Pfizer-BioNTech вакцин хийлгэсэн хүмүүсийн халдварын тархалтыг эсрэгбие сөрөг байсан хүмүүсийн өвчлөлтэй харьцуулсан болно. Энэхүү судалгаагаар вирусын В.1.1.7 хувилбарын эсрэг вакцины тооцоолсон үр дүн 87%, В.1.351 хувилбарын эсрэг 72.1% гарсан байна.

**Хүснэгт 1.** Катар улсад Ковид-19-ийн халдварын болон өвчний эсрэг  
вакцины үр нөлөө

Өвчлөл/Халдварын төрөл	PCR-ээрэг хүмүүс		PCR-сөрөг хүмүүс		Үр нөлөө (95% CI)*
	Вакцин хийлгэсэн	Вакцин хийлгээгүй	Вакцин хийлгэсэн	Вакцин хийлгээгүй	
<b>Халдвар</b>					
Вирусын В.1.1.7 хувилбар PCR шинжилгээгээр батлагдсан					
1 тунгийн дараа	892	18075	1241	17726	29.5 (22.9-35.5)
2 тунгийн дараа ≥14 хоног	50	16354	465	15939	89.5 (85.9–92.3)
Вирусын В.1.351 хувилбар PCR шинжилгээгээр батлагдсан					
1 тунгийн дараа	1329	20,177	1580	19926	16.9 (10.4–23.0)
2 тунгийн дараа ≥14 хоног	179	19,396	698	18877	75.0 (70.5–78.9)
<b>Өвчлөл</b>					
Вирусын В.1.1.7 хувилбараас шалтгаалан үхлийн аюулд хүрэх ноцтой, хүнд өвчтэй					
1 тунгийн дараа	30	468	61		54.1 (26.1–71.9)
2 тунгийн дараа ≥14 хоног	0	401	20		100.0 (81.7–100.0)
Вирусын В.1.351 хувилбараас шалтгаалан үхлийн аюулд хүрэх ноцтой хүнд өвчтэй					
1 тунгийн дараа	45	348	35	358	0.0 (0.0–19.0)
2 тунгийн дараа ≥14 хоног	0	300	14	286	100.0 (73.7–100.0)
SARS-CoV-2 вирусын өөр ямар нэг хувилбараас шалтгаалан үхлийн аюулд хүрэх ноцтой хүнд өвчтэй					
1 тунгийн дараа	139	1966	220	1885	39.4 (24.0–51.8)
2 тунгийн дараа ≥14 хоног	3	1692	109	1586	97.4 (92.2–99.5)

Эх сурвалж:

[NEJM article: Dr. Laith Abu-Raddad, of Weill Cornell Medicine-Qatar, and Dr. Adeel Butt, of the Hamad Medical](#)

## **ДӨРӨВ. ВАКЦИНТАЙ ХОЛБООТОЙ ХЯМРАЛЫН МЭДЭЭЛЭЛ, ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ ХҮНДРЭЛИЙН (ДДУХ) ТУХАЙ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ТОВЧ ЗААВАР**

---

Дэлхийн олон улс орон Ковид-19-н эсрэг вакциныг нэвтрүүлж, хүн амыг дархлаажуулж байгаа нь гайхалтай боломж юм. Энэ үетэй зэрэгцээд олон тулгамдсан асуудлууд гарч ирж байна. Эдгээр асуудлуудаас вакцинтай холбоотой гарч болзошгүй үйл явдал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, түүний эсрэг хариу арга хэмжээ авахад бэлдэх шаардлагатай байна. Коронавируст халдварын эсрэг олон вакциныг олон төрлийн технологи ашиглан маш хурдтайгаар бүтээж, баталгаажуулан, хүн амыг ялангуяа өндөр настай хүмүүсийг дархлаажуулж байна. Энэ нөхцөл байдал зарим хүнд ойлгомжгүй, төвөгтэй байдлыг бий болгож байна. Мөн нөгөө талд олон хүн вакцин хийлгэхийг хүсэж, хэвийн амьдралдаа эргэн ороход нэг алхам ойртож байна гэж үзэж байна.

Ямар ч вакцины үед ДДУХ гарах магадлалтай байдаг. Ковид-19-н эсрэг вакцин хийгдэж эхлэхэд вакцинаас шалтгаалсан болон шалтгаалаагүй урвал хүндрэл гарах боломжтой. Тухайлбал: өндөр настай архаг хууч өвчтэй хүмүүс вакцин хийлгэсний дараа хүндээр өвдөж улмаар нас барж болно. Энэ үйл явдал вакцинтай холбоогүй байж болно. Гэхдээ ийм тохиолдлуудыг олон нийтэд хэрхэн мэдээлэх вэ гэдэг төвөгтэй асуудал гарч ирнэ. Мөн бид вакцин эсэргүүцэгч гэх хямралын эсрэг хариу арга хэмжээ авах шаардлагатай болно. Эдгээр асуудлуудад вакциныг хурдан хугацаанд гарган авсан байдал, вакцинжуулалтыг богино хугацаанд зохион байгуулж байгаа байдал, вакцин хөгжүүлэхэд шинэ технологи ашигласан, насанд хүрэгчдийг дархлаажуулсан, хэт их буруу ташаа мэдээлэл тархах боломж зэрэг нөхцөл байдлууд улам сөргөөр нөлөөлж болзошгүй.

Самоа улсад улаанбурханы эсрэг вакцинжуулалтын үед, Филиппин улсад Денге өвчний эсрэг вакцинжуулалтын үед, Япон улсад HPV вакцин хийх үед гарсан үйл явдлуудаас харахад вакцинтай холбоотой хямрал, ДДУХ-аас үүдэлтэй үйл явдлууд нь хэдэн сар жилээр хүмүүсийн дархлаажуултад итгэх итгэлийг байхгүй болгож, нийгмийн эрүүл мэндэд удаан хугацааны туршид хор нөлөө үзүүлдэг байна. Цаг алдалгүй тухайн үйл явдлын эсрэг хариу арга хэмжээ аваагүйгээс уг асуудлыг улс



төржүүлж, улмаар дархлаажуулалтын хамралт буурч, цаашид вакцинтай халдварт өвчний дэгдэлт гарах шалтгаан болно.

Нөгөө талд, ямар нэг хямрал гарснаар манлайлал, бусдын төлөө санаа зовних, бусдыг өрөвдөх хайрлах зэрэг чадваруудыг үзүүлэх боломж гардаг. ДДУХ-н талаар эрт мэдээлэх нь эрүүл мэндийн салбарт итгэх итгэлийг бий болгодог. ДДУХ, вакцинтай холбоотой хямралын талаар үр дүнтэй эрсдэлийн харилцаа холбоог хэрэгжүүлснээр дархлаажуулалтын хамралтад нөлөөлөх сөрөг үр дагаврыг бууруулж, вакцинд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.

### **Энэ зааврыг хэрхэн ашиглах вэ?**

Энэ заавар нь бүс болон дэлхийн хэмжээний “Дархлаажуулалтын аюулгүй байдлын тандалт”-н зааврууд, “Ковид-19-н вакцины аюулгүй байдлын харилцаа холбооны модуль” зэрэг заавруудад орсон гол зөвлөмжүүдийг багтаасан болно. Энэхүү зааврыг Ковид-19-н вакцины харилцаа холбооны үндэсний төлөвлөгөөний загварын нэг хэсэг болох вакцинтай холбоотой үйл явдалд бэлдэх, хариу арга хэмжээ авах гэсэн хэсгийг бөглөхөд ашиглаж болно.

Тэмдэглэл: энэ зааварт вакцинтай холбоотой хямрал, ДДУХ гэдгийг хэрхэн тодорхойлсон бэ?

1. Хэрэв ДДУХ-ын эсрэг зөв хариу арга хэмжээ авч чадвал энэ нь цаашид олон нийтийн дунд хямралын мэдээллийн харилцаа үүсэхээс сэргийлж чадах юм.
2. Вакцинтай шууд холбоогүй мөртлөө вакцинд итгэх итгэлийг бууруулах, цаашлаад дархлаажуулалтын хөтөлбөр, эрүүл мэндийн тогтолцоонд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц хямралтай бид нүүр тулж болзошгүй.

## Учирч болох эрсдэл, хямралын эсрэг бэлэн байдлын талаар мэдээлэлтэй байх нь

Тухайн орны сэтгүүлчдийн хувьд дархлаажуулалттай холбоотой гарч байсан үйл явдал, өнгөрсөн туршлага дээрээ тулгуурлаад учирч болох эрсдэл, хямралын талаарх мэдээлэлтэй байх хэрэгтэй. Энэ үүднээс Номхон далайн баруун бүс болон дэлхийн бусад орнуудад гарч байсан хямралын зарим жишээг дор харуулав. Өмнөх тохиолдлуудаас сурсан сургамж юу байв? Энэ удаагийн вакцин өмнөх вакцинуудаас ямар ялгаатай байгаа зэрэгт анхаарлаа хандуулж, ямар эрсдэл гарч болохыг анхаарах хэрэгтэй.

### Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл (ДДУХ)

ДДУХ нь вакцин болон вакцинжуулах үйл ажиллагаатай холбоотой эсвэл холбоогүйгээр вакцин тариулсны дараа гарч ирэх эмгэг тохиолдлыг хэлнэ.

ДДУХ-н ангилал:

- Санаа зовж, айж түгшсэнтэй холбоотой: вакцин хийлгэх айдсаас үүдэлтэй ухаан алдах, өвчлөх. Зарим хүний харах болон сонсох мэдрэхүйгээр сэтгэлзүйн шинж тэмдэг дамждаг. Тухайлбал вакцин хийлгэх явцад ухаан алдаж унасан хүнийг хараад өөрөө вакцин хийлгэх үедээ ухаан алдах тохиолдол байдаг байна. Шалтгаан нь сэтгэлзүйтэй холбоотой бөгөөд сэтгэл зовнилтой холбоотой үүсэх ДДУХ-н үед хүмүүст илрэх шинж тэмдэг нь бодит бөгөөд муужрах, дотор муухайрах зэрэг шинжүүд илэрдэг байна. Энэ тохиолдолд хүмүүст энэ зүйл таны тархи, толгойд л байгаа асуудал гэж хэлж болохгүй бөгөөд тухайн хүний оронд өөрийгөө тавьж, түүнийг хайрлах өрөвдөх сэтгэлээр харилцах ёстой.
- Вакцинтай давхацсан эмгэг: вакцин хийлгэх цаг мөчтэй давхцан тухайн хүн өөр өвчнөөр өвдөх, улмаар нас барах тохиолдлууд орно. Энэ тохиолдолд шалтгааныг шинжилгээ, судалгаа хийж тодорхойлно. Коронавирусийн вакцины тухайд өндөр настай, архаг хууч өвчтэй хүмүүст вакциныг хийж байгаа. Тиймээс вакцинтай давхацсан эмгэг илрэх тохиолдлын тоо

харьцангуй олон байж болзошгүй бөгөөд вакцин хийлгэсэн цаг хугацаатай зэрэгцээд өөр өвчин эмгэг илэрч болзошгүй. Тиймээс вакцин хийж эхлэхээс өмнө хүмүүст вакцинтай давхацсан эмгэгийн талаар ойлголт өгөх нь дараа нь гарах сөрөг үр нөлөөг бууруулах ач холбогдолтой.

- Вакцин тээвэрлэх, хадгалах, тарихтай холбоотой үүссэн алдаа буюу хөтөлбөрийн алдаанаас үүдэлтэй ДДУХ: вакцин хийж байгаа хүн буруу шингэнээр тарьсан, буруу хадгалсан вакцин тарих гэх мэт тохиолдлуудад энэ төрлийн ДДУХ үүснэ. Энэ тохиолдолд шалтгаан нөхцөлийг тодорхойлох судалгааг хийнэ.
- Хөнгөн болон дунд зэргийн вакцины хариу урвал: вакцин тарьсан хэсэг газарт улайх, өвдөх зэрэг урвал илрэх нь түгээмэл бөгөөд халуурах, бие өвдөж зовиурлах зэрэг шинж тэмдэг нь дархлааны хариу урвалын илрэл юм. Энэ шинж тэмдэг олон вакцины үед илрэх бөгөөд тухайлбал БЦЖ, улаанбурханы вакцины үед илэрдэг. Тиймээс урьдчилаад хүмүүст энэ төрлийн хэсэг газрын урвал илрэх боломжтой гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ямар арга хэмжээ авахыг тайлбарлах нь (халуун бууруулах зорилгоор парацетамол хэрэглэх гм) хүмүүс айх, сандрахаас сэргийлнэ.
- Вакцины хүнд урвал: уналт таталт болон харшлын хүнд урвал (анафилаксын шок) зэрэг орно. Вакцины хүнд урвал маш ховор тохиолддог боловч олон хүнийг хамарсан масс вакцинжуулалтын үед ийм тохиолдол олон гарч болзошгүй. Учир нь 100 000 хүн амд 1 тохиолдол илрэх магадлалтай байдаг энэ эрсдэл 50 сая хүнийг дархлаажуулах явцад 500 хүнд харшлын хүнд урвал илрэх магадлалтай гэсэн үг. Тиймээс ард иргэд хүнд хэлбэрийн харшлын урвалын үед илрэх шинж тэмдгийн талаар мэдээлэлтэй байх ёстой.

Эдгээр гарч болзошгүй урвал, хүндрэлд бэлдэхийн тулд ард иргэдэд энэ талаарх мэдээлэл болон түгээмэл илрэх хэсэг газрын урвал, гарч болох эрсдэл, вакцин хийлгэхийн ач холбогдол, вакцинжуулалтын талаар гэх мэт мэдээллийг урьдчилан эрт хүргэх нь чухал. ДДУХ-н эхний тохиолдол бүртгэгдэхэд зарим шалтгаан нөхцөл нь тодорхойгүй байж болох бөгөөд энэ үед хэвлэл мэдээллийнхэн, редакторууд юу

хийсэн, ямар хариу арга хэмжээ авч байгаа талаар зохих эх сурвалжаас мэдээлэл авч тогтмол мэдээлэл хүргэх нь чухал юм.

### **Нэр алдартай хүмүүсийн дуу хоолой вакцинд итгэх итгэлийг үгүй хийж чадна**

Вакцин хийлгэх хүсэл сонирхол их болох үед хүмүүс вакцины холбогдолтой асуудалд хандахдаа баримт нотолгоонд бус өөрийн мэдрэмж, ойлголтод илүү тулгуурлана. Нэр алдартай хүн вакцины талаар сөрөг дуу хоолойг олон нийтэд хүргэх нь нийтийн өргөтгөсөн вакцинжуулалтын ажилд саад болох нөлөөтэй. Тиймээс дараах гарч болзошгүй асуудлуудад бэлэн байх ёстой:

- Вакцин эсэргүүцэгчдийн нөлөө, дуу хоолой- вакцин эсэргүүцдэг нэр хүндтэй хүн сөрөг мэдээллийг тараахад хүн амын зарим хэсэгт тэр мэдээлэл нь нөлөөлдөг. Эдгээр эсэргүүцэгчид тухайн орны эсвэл гадаад орны хүмүүс байж болдог.
- Улс төрийн сөрөг хүчин: засгийн газрын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх зорилгоор вакцинтай холбоотой сөрөг мессежүүдийг ашигладаг.
- Шашны удирдагч нар: вакцин, вакцинжуулалтын үйл ажиллагааг шашинд нь зөвшөөрдөггүй гэж хэлдэг.
- Вакцин эсэргүүцдэг эрүүл мэндийн ажилтнууд: эдгээр хүмүүс нэг эсвэл хэд хэдэн вакцины эсрэг үзэл бодолтой байдаг байна. Ковид-19-н вакцины хувьд вакцин хөгжүүлэлттэй холбоотой, эмнэлзүйн туршилтыг богино хугацаанд хийсэн тухай, шинэ технологи ашиглаж байгаа зэрэгт анхаарлаа хандуулан олон нийтэд вакцины тухай эсрэг байр сууриа илэрхийлж болзошгүй.

Дээрх хүмүүс бол олон нийтэд нөлөө үзүүлж чадах дуу хоолойнууд бөгөөд цахим сүлжээнд цөөхөн дагагчтай тролл бүрийн эсрэг хариу арга хэмжээ авах шаардлагагүй. Харин, сөрөг мэдээлэл гаргагчийн үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, ямар хариу арга хэмжээ авахаа /тухайн мэдээллийн талаар мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээс тодруулах, баримт нягтлан шалгах ажил хийх, эрэн сурвалжилсан өгүүлэл бичих, шууд ярилцлага хийх... г.м / редакцияараа зөвлөлдөх нь чухал юм. Ил тод, шуурхай мэдээллийг олон нийтэд хүргэх нь сөрөг дуу хоолой

хүн амын дунд газар авахаас сэргийлнэ. Учир нь мэдээллийн вакуум орчинд буруу ташаа мэдээлэл маш хурдтай тархдаг байна.

### **Олон нийтэд хүргэж байгаа мессэжийн зөрүүтэй байдлаас болж итгэл алдарч, төөрөгдөл үүсгэнэ**

Засгийн газрын олон байгууллага мэдээллийн хувьд зөрүүтэй мессэж түгээх тохиолдол гардаг. Энэ тохиолдолд хүн амын дунд төөрөгдөл үүсэх, улмаар итгэл алдрахад хүргэнэ. Тиймээс улс орнууд байгууллагуудын хоорондын мэдээлэл харилцааны үйл ажиллагаанд зохицуулалт хийхийг чухалчилдаг. Энэ нь мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлнэ. Харин хэвлэл мэдээллийнхэн улс орондоо ийм мэдээлэл харилцааны зохицуулалт байгаа эсэх, тэнд хэн ажиллаж байгааг яаралтай мэдэж авах нь дархлаажуулалтын үеийн мэдээллийн чухал эх сурвалж болох юм. Ингэснээр тохиолдож болох эрсдэлийн тухай ил тод мэдээлэх, тодорхойгүй байдлыг мэдээлэх зэрэг эрсдэлийн мэдээлэл харилцаанд сэтгүүлчид хувь нэмрээ оруулснаар удаан хугацаандаа дархлаажуулалтад олон нийтийн итгэлийг бий болгоход чухал нөлөөтэй юм.

### **Өргөтгөсөн нийтийн вакцинжуулалтын ажил зогсох**

ДДУХ нь өргөтгөсөн вакцинжуулалтын ажил зогсоход хүргэж болзошгүй. Зарим тохиолдолд болсон үйл явдалтай холбоотой судалгаа, дүгнэлт хийх зорилгоор вакцинжуулалтын ажлыг түр хугацаагаар зогсоож болзошгүй. Тиймээс тухайн үйл явдлын талаар зөвхөн шинжлэх ухаанд суурилсан баримт, бодит мэдээллийг бэлтгэж, түгээхдээ эрүүл мэндийн салбарынхаа бодлого, чиглэлийг харгалзах, хэт дуулиан шуугианаас зайлсхийх, хэрэглэгчдийнхээ мэдээллийн эрэлт, хэрэгцээг зөв мэдрэх зэргээр сэтгүүл зүйн үүрэгт ажлаа сэтгүүлч, редакторууд хянамгай зохион байгуулснаар вакцинжуулалт дахин эхлэх боломжтой болдог ба вакцинжуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрт нөлөөлөх нөлөөллийг бууруулах боломжтой юм. ДДУХ-ийг илрүүлэх, түүний эсрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх найдвартай механизмын тухай мэдээллийг хэвлэл мэдээллийнхэн нээлттэй, аль болох эрт

хүргэж эхлэх нь хүмүүсийн итгэлийг нэмэгдүүлэхэд тусална. Ингэж мэдээлэх нь судалгаа, шинжилгээ хийхэд тодорхой цаг хугацаа зарцуулдаг, ихэнх тохиолдлууд вакцинтай холбоогүй байдаг зэргийг ойлгож, мэдэж авахад тусална. Хэрвээ вакцинжуулалтын ажлыг түр зогсоохоор болбол гаргаж буй шийдвэрийн тухай нээлттэй мэдээлэх, хэзээ дахин эхлэх талаар мэдээлэх нь маш чухал. Хөрш зэргэлдээх орнуудын вакцинжуулалт зогссон тухай болон үндэсний хэмжээнд болж буй том өөрчлөлт, үйл явдлын (коронавируст халдварын тохиолдлын тоо ихэссэн тухай гм) тухай урьдчилж (проактив) мэдээлэл хүргэх нь чухал.

### **Урьдчилан таамаглаагүй нөхцөл байдалд бэлдэх**

Урьдчилан таамаглаагүй хямрал улс оронд үүсэн үед хэвлэл мэдээлэл хэрхэн ажиллах вэ? Юуны өмнө энэ тохиолдолд мэдээллийг олон нийтэд хүргэх мэргэшсэн мэргэжилтэн Засгийн газрын түвшинд болон өөр аль нэг салбарт байгаа эсэх, хариу арга хэмжээг хэрхэн авах талаарх механизм бий болсон эсэхийг эртнээс тандаж, харилцаа холбоо тогтоосон байх ёстой. Ингэснээр цаг алдалгүй, ил тод байдлаар мэдээллийг олон нийтэд хүргэх боломж бүрдэнэ.

### **ДДУХ болон ямар нэг хямрал гарахаас өмнө**

ДДУХ болон ямар нэг хямрал гарахаас өмнө хэрхэн олон нийтэд мэдээллийг хүргэх вэ?

ДДУХ болон ямар нэг хямрал гарахаас өмнө болгоомжтойгоор мэдээ мэдээллийг хүргэх нь асуудал гарах үед бүх нийтээрээ сөрөг хариу урвал үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг. Ийм төрлийн мэдээ мэдээллийг дархлаажуулалтын бүхий л цаг хугацааны турш түгээх бөгөөд кампанит ажлын туршид үргэлжлүүлнэ. Энэ үйл ажиллагааны явцад хэвлэл мэдээллийн байгууллагуудын анхаарах гол зарчмууд:

- Нээлттэй, ил тод мэдээ мэдээллийг хүргэх: вакцинжуулалтын ашиг тусын тухай мэдээлэхдээ гарч болох эрсдэлийн тухай ил тод мэдээлж, ДДУХ-ыг илрүүлэх, түүний эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоо бий гэдэг

мэдээллийг хүргэх хэрэгтэй. Гарч болох эрсдэлийн талаар илэн далангүй мэдээлэх нь мэдээлэл-нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад нь нөлөөлж, ДДУХ илэрсэн үед цочролд бага өртөнө.

**Олон нийтэд өгч буй мессэж, мэдээлэлд сэтгүүлчид дараах агуулгыг багтаасан байна:**

- ДДУХ гэж юуг хэлэх вэ, үүнийг яагаад хянаж, тандах ёстой вэ?
- Вакцины аюулгүй байдал, үр дүнг үнэлдэг эмнэлзүйн туршилт судалгааны ач холбогдол,
- Вакцины аюулгүй байдал, илэрч болох ДДУХ-н тухай, туршилт судалгааны явцад ДДУХ хэдэн хувьтай илэрч байсан,
- Одоогоор тодорхой болсон зүйлс, цаашид хийх шаардлагатай зүйлс
- ДДУХ-н байнгын хяналтыг хийх төлөвлөгөө,
- Вакцины ашиг тусын тухай

**Дараах зүйлсийг сэтгүүлчид анхаарах хэрэгтэй:**

- Хэтрүүлэн амлалт өгч болохгүй: ямар ч вакцин 100% аюулгүй биш. Ковид-19-ын эсрэг вакцинууд шидэт эм биш бөгөөд вакцин хийнгүүт өвчний дэгдэлт алга болохгүй гэдгийг сэтгүүлчид мэдээ, мэдээлэл бэлтгэхдээ, эх сурвалжтай ярилцахдаа байнга санаж байх.
- Тодорхой биш зүйлийг хэл: ковид-19-ын эсрэг вакцин шинэ вакцин учраас маш олон тодорхойгүй зүйл байгаа. Юуг мэдэж байгаа болон юу мэдэхгүй байгааг мэргэжлийн эх сурвалжаас лавлаж тодорхой мэдээлэх нь зүйтэй.
- Редакторууд баттай эх сурвалжаас мэдээ мэдээлэл авахыг дэмжиж, буруу ташаа мэдээлэл тараахгүй байхад сэтгүүлчдэдээ дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

## Юу бэлтгэх вэ?

Тэмдэглэл: уг шалгах хуудсыг Ковид-19-н төлөвлөлтийн загварын хамт хэрэглэнэ.

Монгол улсад эрсдэлийн харилцаа холбоо болон мэдээлэл харилцаа холбооны стратегийг ямар ямар түвшинд боловсруулсан, хаана, хэн баримталж байгааг хэвлэл мэдээллийн байгууллагын редакторууд олж мэдэх нь найдвартай мэдээлэлтэй болох чухал түлхүүр юм. Хэвлэл мэдээллийнхэн тэдгээр стратегийг хэрэгжүүлж буй, үр дүнг үнэлж, хянаж буй мэргэжилтнүүдтэй холбоотой байж хамтран ажиллах шаардлагатай.

Харин тухайн стратегийн агуулгад дараах зүйлс багтсан эсэхийг редакторууд заавал шалгаж, сэтгүүл зүйн бүтээлийн сэдэв, өнцөгтөө харгалзах хэрэгтэй.

- ДДУХ болон вакцинтай холбоотой хямралд хэрхэн хариу арга хэмжээ авах стандарт,
- Яаралтай нөхцөл байдал үүссэн үед мэдээллийг түгээх процесс,
- Ерөнхий сайд, ерөнхийлөгч болоод үндэсний түвшинд мэдээлэл харилцаа холбоог зохицуулах механизм,
- Үндэсний болон орон нутгийн түвшинд засгийн газрын байгууллагуудын хооронд мэдээлэл харилцаа холбоог зохицуулах механизм,
- Олон улсын байгууллагууд (ДЭМБ, НҮБХС)-д мэдээлэл харилцаа холбоог зохицуулах механизм,
- Вакцинтай холбоотой хямралын тухай мэдээллийг олон нийтэд хүргэх, мэргэшсэн боловсон хүчнийг томилсон эсэх,
- Олон нийтийн үзэл бодлыг тодорхойлох зорилго бүхий мэдээллийн олон эх үүсвэрийг (утас, тандалт судалгаа, цахим сүлжээг тандах) нэгтгэсэн тогтолцоо,
- Гол зорилтот бүлэг, тэдгээрийн мэдээлэл авах үндсэн суваг, олон нийтэд нөлөөлөгч нарын матрикс



Эдгээр зүйлс танай редакцад аль хэдийн бий болсон байж болох ч шаардлагатай гэж үзвэл жагсаалтыг шинэчлэх, сайжруулж болох юм. Дархлаажуулалттай холбоотой үйл явдлын үед редакцийн ажлыг зөв зохион байгуулахын тулд редакторууд дараах ажлыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

#### Редакторуудын хэрэгжүүлэх ажлууд:

- ДДУХ болон дархлаажуулалтын үеийн ямар нэг хямрал үүсэн үед мэдээллийг ил тод, түргэн шуурхай түгээх засгийн газрын дээд түвшний зөвшөөрлийг олж авах,
- Редакцууд вакцины аюулгүй байдлын төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаа хэрхэн болдог талаар мэдээлэлтэй байх нөхцлийг өөртөө бүрдүүлэх,
- Олон төрлийн ДДУХ, вакцины аюулгүй байдлын талаар мэдээлэх тухайн үйл явдлын талаар редакцын өнцгийг илтгэсэн мессеж боловсруулах, урьдчилж тест хийх, нөхцөл байдалд тохирсон мессежийн матрикс, мессежийн агуулга бэлдэх,
- Үндэсний болон орон нутгийн түвшинд ажиллах харилцаа холбооны мэргэжилтэн, олон нийтэд мэдээлэл өгөх хүнтэй эртнээс холбоотой байж, шаардлагатай үед шуурхай мэдээлэл авахаар тохиролцоонд хүрсэн байх,
- Сэтгүүлчдээ вакцин, ДДУХ-тэй холбоотой асуудлаар мэдээллийг хэрхэн хүргэх талаар мэргэжлийн байгууллагын сургалтад хамруулах,
- Хүн амын дундах вакцин хийлгэхэд нөлөөлж байгаа хөдөлгөгч хүчин зүйл болон саад болж буй хүчин зүйлсийг тогтмол тандан судлах,
- Цахим сүлжээ, утсаар ирж буй иргэдийн асуултад хариулах ажилтан болон сайн дурын ажилчдыг ажиллуулах гэх мэт редакцын эргэх холбоо, түүний хүрээг нэмэгдүүлэхэд шаардлагатай хүний нөөц, мөнгө санхүүг бэлтгэсэн байх,

- Вакцины кампанит ажилд сөргөөр нөлөөлж байгаа хүмүүстэй хэзээ, хэрхэн харилцаа холбоо тогтоох шийдвэр гаргахад туслах зааварчилгаа гаргах,
- Найдвартай эх үүсвэрээс хүн амд зөв мэдээллийг түгээх, буруу ташаа мэдээллээс сэргийлэх, нөлөөг бууруулах зорилгоор цахим сүлжээний томоохон компаниудтай хамтран ажиллах,
- Олны дунд нэр хүндтэй нөлөөлөгч, лидерүүдтэй хамтран ажиллах. Вакцины аюулгүй байдлын тогтолцооны тухай хүн амд хүргэх мэдээллийг хамтран боловсруулах зэргээр харилцаа холбооны стратегийн үйл ажиллагаанд оролцуулах.

### **ДДУХ болон хямрал гарсан үед мэдээ мэдээллийг хэрхэн хүргэх вэ?**

Ямар нэг хямрал эсвэл ДДУХ гарсан үед түүний талаар мэдээлэл хүргэх нь нэлээд төвөгтэй бөгөөд бид сурсан дадсанаараа хүмүүсийг тайвшруулж болох юм. Гэхдээ яг юу болоод байгаа талаар нээлттэй, ил тод мэдээлэх, бусад хүнээс түрүүлж проактив байдлаар мэдээ мэдээлэл түгээх нь итгэл төрүүлэхэд маш чухал ач холбогдолтой. Яг бодит мэдээллийг сонсоод хүмүүст айж түгшинэ гэж бодож болохгүй. Мэдээллийг нуух, дарах нь эргээд итгэл алдахад хүргэнэ. Өнөөгийн цахим эрин үед мэдээлэл маш хурдтай тархана. Хэрэв гарсан асуудлын талаарх мэдээллийг чи хүргэхгүй бол өөр хэн нэг нь өөрийн зорилгодоо нийцүүлэн мэдээлэх болно. Дараах зарчмуудыг баримталснаар тухайн гарсан асуудлын талаарх хүмүүсийн ойлголтыг сайжруулах, удаан хугацаанд хүмүүсийн итгэлийг олж авахад том түлхэц болно.

### ДДУХ болон хямрал гарсан үед мэдээ мэдээллийг түгээх зарчим

- Хамгийн эхэнд мэдээллийг хүргэх: хүмүүс хамгийн эхлээд сонссон мэдээллийн эх сурвалж болон хамгийн эхэнд хүлээж авсан мессежид итгэх хандлагатай байдаг. ДДУХ болон хямралын талаар яг одоо мэдэгдэж байгаа зүйл бага байгаа ч гэсэн хамгийн эхлээд мэдээллийг хүргэх нь танай мэдээллийн үнэ цэн болон түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.
- Олон нийтэд мэдээллийг давтамжтай хүргэх: хэдийгээр шинэ мэдээлэл байхгүй байсан ч олон нийтэд тодорхой давтамжтайгаар шинэчлэгдсэн мэдээллийг хүргэх.
- Ил тод байх: хэдийгээр зарим зүйлс тодорхойгүй байгаа ч юу болсныг шударгаар хэлэх. Асуудлыг тодорхой болгох чиглэлээр юу хийж байгааг тайлбарлах, хэлэх хэрэгтэй.
- Хүмүүсийг хэт тайвшруулж болохгүй: тухайлбал-ихэнх ДДУХ вакцинтай шууд холбоогүй байдаг гэдгийг мэдээлсэн ч ноцтой ДДУХ гарч болдог учраас ДДУХ -ийг тандах тогтолцоо байдаг гэдгийг ойлгуулах
- Бусдыг ойлгох чадвартай байх: хүмүүсийг ойлгож, тэдэнд санаа зовж байгаагаа харуулах
- Олон нийтээс зүгээс түгээмэл асууж байгаа болон анхаарал хандуулж байгаа асуудалд хариулт өгөх: бид хараахан мэдэхгүй байна гэж хариулахаас өөр хариулт байхгүй байсан ч хариулт өг. Буруу ойлголт, цуу яриаг анхааралдаа ав.
- Хүмүүс баттай мэдээллийг ямар эх үүсвэрээс авч болохыг хэлж өгөх: утас, вэбсайт, цахим сүлжээ гэх мэт

### Сэтгүүлчид юу хийх вэ?

ДДУХ болон хямрал мэдээлэгдсэнээс хойш сэтгүүлчид тухайн орчин, орон нутагтаа 1-2 хоногийн дотор дараах байдлаар ажиллана:

- Тухайн хот, орон нутгийн мэдээлэл харилцаа холбооны багийн гол хүмүүстэй хамтран ажиллаж, тэднийг эх сурвалжаа болгохоос гадна боломжтой бол хамтдаа уг үйл явдлын вакцинжуулалтад үзүүлэх нөлөөг үнэлэх, мэдээлэл харилцаа холбооны хариу арга хэмжээний цар хүрээг тодорхойлоход оролцох,
- Одоогийн нөхцөл байдлын талаарх мэдээллийн гол сэдэв, өнцөг, агуулгаа боловсруулах, шинэчлэх,
- Болсон үйл явдлыг нэн даруй мэдээлэх. Одоогоо тодорхой бус байгаа зүйлийн талаар нээлттэй байх, илүү мэдээлэл цуглуулах, баримтыг нягталж шалгах ажилд гол анхаарлаа хандуулах,
- Холбогдох яамд, байгууллагаас хүсч буй мэдээллээ эртхэн хүргүүлэх,
- Засгийн газар болон хамтрагч байгууллагууд тэнцвэртэй мэдээллийг хүргэх зохицуулах механизмыг идэвхижүүлсэн эсэхийг тандаж, холбоотой ажиллах,
- Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг мэдээллийн зөвлөхөөр ажиллуулж, нөлөөлөгчдөөс ирж буй асуултад хариулах редакцын чадавхийг сайжруулах, цахим сүлжээ, утас зэрэг мэдээллийн хоёр талт харилцааг бий болгох,
- Зорилтот хэрэглэгчиддээ тохирсон мэдээллийн агуулга, сэдвээ боловсруулах, шинэчлэх, түүнийгээ редакцын ажлын төлөвлөгөөнд оруулах,
- Олон нийтийн хандлага, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор тасралтгүй хяналт үнэлгээ хийх тогтолцоог хэвлэл мэдээллийн сувгаараа /сэтгэгдэл хэсгийг ажиглах, шуурхай сурвалжлага зохион байгуулах гэх мэт/ ажиллуулах,
- Олон нийтэд шинэчлэгдсэн мэдээллийг товч, тодорхой давтамжтай хүргэхээр редакцын төлөвлөгөөнд тусгах.

## ДДУХ болон хямралын дараа

Тухайн асуудлыг дуусгахаас өмнө ДДУХ-ын үйл явцыг тоймлох, судалгааны дүнг тайлагнаж, олон нийтэд мэдээлэх хэрэгтэй. Судалгааны үр дүнг ил тод мэдээлэх нь удаан хугацаанд хүмүүсийн итгэлийг олж авахад хэрэгтэй. Эцэст нь хэвлэл мэдээллээр ил тод мэдээлэл түгээж байж эрүүл мэндийн салбарын болон Засгийн газар бусад түвшинд сурсан сургамж, олж авсан туршлага дээрээ үндэслэн ДДУХ болон хямралын стратеги, төлөвлөгөөг шинэчлэх боломжтой. Энэ нь сэтгүүл зүй цар тахлын үед нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтдээ үйлчилж буй хэлбэр юм.

### Хавсралт 1: Редакторууд хэзээ, хэрхэн сөрөг дуу хоолойтой харилцаа холбоо тогтоох вэ гэдгийг тодорхойлох заавар

1. Сөрөг мэдээлэл тараагаад байгаа энэ хүнд зориулж хариу арга хэмжээ авах нь тийм чухал уу гэдгийг тодорхойл
  - Энэ хүний үзүүлж байгаа нөлөөлөл хэр их вэ? Энэ хүний хэлсэн үг олон нийтийн бусад мэдээллийн хэрэгслээр дахин дахин давтагдаж байна уу, тодорхой бүлэг хүн ам энэ хүний хэлсэн үгийг ноцтойгоор хүлээж авч байна уу?
  - Цахим сүлжээгээр их тархаж байна уу, олон дагагчтай байна уу, хэдэн хүн лайк, шэйр хийсэн байна вэ?
2. Хариу арга хэмжээ авахаас өмнө энэ хүнийг ямар зүйл өдөөдөг, урам зориг өгдгийг тодорхойл:
  - Олон нийтэд тарааж байгаа мэдээлэл нь буруу ойлголт уу? Санамсаргүйгээр худал цуу яриаг олон нийтэд тараачихсан уу?
  - Мэдээллийг вакцин эсэргүүцдэг хүн тараагаад байна уу? Хэрэв тийм бол тэдний үзэл бодлыг өөрчлөх бараг боломжгүй.
3. Тухайн хүний эсрэг хариу арга хэмжээг хэн авч хэрэгжүүлэх вэ гэдгийг тодорхойлох. Тухайн сөрөг мэдээлэл тараагч өндөр түвшний албан тушаалтны зүгээс хариу өгөх түвшний хүн үү? Эсвэл олон нийтэд нөлөөлөгч, хамтран ажиллагч байгууллага, харилцаа холбооны аль нэг мэргэжилтэн

эсвэл орон нутгийн түвшний мэргэжилтнүүдийн зүгээс хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой байна уу?

4. Шаардлагатай үед хариу арга хэмжээ ав. Гэхдээ хүндэтгэлтэй ханд. Сөрөг мэдээлэл тараагчийг дэмжигч эсвэл хараахан аль талыг дэмжихээ шийдээгүй байгаа хүмүүс танай редакцын мэдээллийг үзэж байгаа. Тиймээс эелдэг бай.
  - Хэрэв тэр хүн баримт мэдээллийг буруу ойлгосон, эсвэл асуулт, санаа зовнисон зүйл байгаа бол тэдэнд шууд хандсан байдлаар хариу арга хэмжээг хэрэгжүүл
  - Хэрэв тэр хүн вакцин эсэргүүцэгч бол тэдний анхаарлыг татах зүйл битгий хий. Харин түүний оронд баримт нотолгоотой мэдээллийг олон эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан олон нийтэд түгээх. Хэн нэг хүний нэрийг дурдахгүйгээр, дараах томъёог ашиглах: та магадгүй (буруу мэдээллийг оруулах) гэж сонссон байх. Гэхдээ баримт нотолгоо бол (зөв мэдээллийг оруулах) юм.
5. Цахим орчинд тараагдаж байгаа буруу ташаа, алдаатай мэдээллийг нягталж шалгах /Fact Check/ ажил хийж, шаардлагатай бол вакцины эсрэг үйл ажиллагаа явуулагчдын буруу мэдээллийг залруулж мэдээлэх.

## Хавсралт 2: Сэтгүүл зүйн бүтээлд ашиглаж болох ДДУХ-н тухай түлхүүр мессеж

ДДУХ-н тухай мэдээллийг хүргэхэд дараах мессежийг ашиглах боломжтой. Тухайн орны нөхцөл байдал, кампанит ажил, вакциндаа тохируулан мессежийг шинэчлэн ашиглах боломжтой. Вакцины тухай илүү нарийн мессежийг *How to talk to the public about COVID-19 vaccines* заавраас харах боломжтой.

- Хүмүүс вакцины аюулгүй байдал, гарч болох хэсэг газрын урвалын тухай асуух нь зүйн хэрэг. Өөрийн болон гэр бүлийнхээ төлөө шийдвэр гаргахад энэ мэдээллийг авах хэрэгтэй.
- Вакцин дээр маш нарийн эмнэлзүйн туршилт судалгааг хийж, аюулгүй, үр дүнтэй байдал нь шалгагдсаны үндсэн дээр хүн амд хэрэглэх зөвшөөрлийг

олгодог бөгөөд гарч болох эрсдэлээс хүн амд өгөх ашиг тус нь хэд дахин илүү гэдгийг баталгаажуулсан байдаг.

- Гэхдээ бусад эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүний нэгэн адил вакцин хийлгэсний дараа зарим хариу урвал илэрч болдог. Үүнд: вакцин хийсэн газрын эргэн тойронд улайх, хөндүүрлэх, бага зэрэг халуурах, бие тавгүйрхэх гэх мэт шинж тэмдэг илэрч болно. Хөнгөн шинж тэмдгүүд хэдэн өдрийн дотор өөрөө аяндаа зүгээр болдог.
- Вакцины хүнд урвал маш ховор тохиолддог. Эмнэлзүйн туршилт судалгаа хийх явцад илрээгүй урвал хүндрэл болон гарч болзошгүй маш ховор хүнд урвалыг манай улс ДДУХ-ийг илрүүлэх, тандан судлах тогтолцоогоор илрүүлдэг. ДДУХ гэдэг нь: вакцин хийлгэсний дараа вакцинаас шалтгаалсан болон шалтгаалаагүйгээр гарч ирэх эмгэг байдлыг хэлдэг.
- ДДУХ-ийг судлаад үзэхэд ихэнх тохиолдолд вакцинтай холбоогүй байдаг. Жишээ нь: вакцин хийлгэсэн цаг хугацаанд өөр эмгэг давхцаж илрэх эсвэл вакцинаас айснаас үүдэлтэй илрэх эмгэг гэх мэт байж болно.
- Вакцин хийлгэснээс үүдэлтэй хүнд урвал гарах боломжтой байдаг тул ДДУХ-н тандалтын тогтолцоо байдаг. ДДУХ гарах үед авах хариу арга хэмжээ авах тухай эмч, мэргэжилтнүүдэд зааж сургасан байдаг. Дараах мэдээллийг нэмэлтээр оруулах: Ямар ямар шинж тэмдэг илэрвэл аюултай гэж үзэх? Шаардлагатай бол эмнэлэгт ханд
- Олон хүний амь насыг аврах учраас таныг вакцин хийлгэхийг зөвлөж байгааг тайлбарлах. Вакцин хийлгэхийн ашиг тус нь гарч болох эрсдэлээс хамаагүй их. Яагаад вакцин хийлгэх ёстой хүчтэй мессежийг нэмж оруулах.

## ТАВ. БИЕ ДААЛТ: КОВИД-19-ИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ НЬ: ВАКЦИНУУД

*/Гарын авлагын энэ хэсэгт бид сэтгүүлчдэд зориулсан Томсан сангийн хичээлийг орчуулан хүргэж байна. Та бүхэн өөрийгөө шалгаж мэдлэгээ нэмээрэй/*

**Вакцин:** Бидний ихэнхи нь вакцин тариулж байсан. Вакцин бидний амьдралыг өөрчилж, уртасгасан. Гэхдээ маргаангүй гэсэн үг биш. КОВИД-19 цар тахлын үед сэтгүүлчдийн гүйцэтгэх чухал үүрэг бол вакцин үйлдвэрлэх, бүтээх явцтай холбоотой шинжлэх ухаан, аюулгүй байдлын асуудлыг судалж, асууж лавлах явдал юм.

### Вакцины талаарх эргэлзээ – Агуулга

Анхны вакцин хэзээ бий болсон бэ?

Хариулт: [зөв хариулт 1796]

- 1918
- 1845
- 1796

Вакцинжуулалтыг эрт дээр үеэс хийж ирсэн боловч вакцины хэрэглээний талаар эргэлзэх, тээнэглээх зүйлс бий. Тухайн үед Эдвард Женнерийг шинжлэх ухааны үүднээс, мөн оюун санааны үзэл бодлын талаас нь вакцинжуулалтыг эсэргүүцэн шүүмжилж байсан. Дулимаг бэлтгэгдсэн дадлагажигчид Женнерийн вакцинжуулах процедурыг сайн ойлгоогүй гүйцэтгэж байсан нь байдлыг улам ээдрээтэй болгож байжээ. Зарим үед өвчний тархалтыг хязгаарлахаасаа илүүтэйгээр тараах явдал ч гарч байсан аж. Сүүлийн үед эрүүл мэндийн байгууллагуудад үл итгэх байдлыг олны анхаарлын төвд байгаа дуулиантай үйл явц дэвэргэж байна.



## **Вакцины талаарх эргэлзээ – Үндсэн мэдээлэл**

### **Судалгааны жишээ: Франц**

Францын өгөгдөл буюу мэдээлэл нийлүүлэгч Ipsos компанийн 2020 оны 12-р сард нийтэлсэн судалгаагаар Францын хүн амын 40% нь л вакцин хийлгэхийг зөвшөөрч байгаа аж. Оросууд Францчуудтай ойролцоо буюу 43% нь вакцин тариулахыг зөвшөөрч байгаа бол энэ үзүүлэлтийг Хятад 80%, Бразил 78%-р тэргүүлж байна.

<https://www.ipsos.com/en/global-attitudes-covid-19-vaccine-december-2020>

### **Итгэлгүй байдал: Франц**

- 1984-1985 оны хооронд Францын Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс (Centre National de Transfusion Sanguine) ХДХВ-ийн халдвартай цусны бүтээгдэхүүнийг мэдсээр байж тараасан нь тогтоогджээ. 4700 гемофили өвчтэй хүн халдвар авч, 300 гаруй хүн нас баржээ.
- Францад борлуулагч чихрийн шижингийн эмийг таван сая гаруй хүнд хоолны дэглэмийн эм болгон өгсөн байдаг. Энэхүү үйлдэл нь мянгаас хоёр мянга орчим хүнийг үхэлд хүргэсэн гэх таамаг бий.

### **Асуулт**

Та ислам шашин зонхилсон улсад ажилладаг сэтгүүлч бөгөөд танай улсад вакцин тариулах нь бага байна. Сошиал медиагаар вакцинд спирт агуулагддаг тухай нийтлэлийг тарааж, олон хүн уншжээ. Исламын шашинд спирт буюу согтууруулах ундааг хориглосон байдаг бөгөөд энэ нийтлэл вакцин тариулах явдал бага байгаатай холбоотой байж болох юм. Вакцинд спирт агуулагддаггүй. Та яах байсан бэ?

- Үл хэрэгсэнэ. Вакцин спирт агуулдаггүй. Энэ тухай дурдах нь магадгүй олон хүмүүсийг цуу ярианы талаар мэдэхэд хүргэнэ.

- Энэ тухай мэдээлнэ. Гэхдээ энэ мэдээлэл худлаа байж магадгүй, сошиал медиад эх сурвалжийг болгоомжтой дурдах хэрэгтэйг тодорхой мэдээлнэ.
- Анагаахын шинжлэх ухааны эрдэмтэн (болж өгвөл Ислам шашинтай) эсвэл найдвартай шинжлэх ухааны байгууллагаас вакцины орц, агуулгыг тодруулж, мөн шашны итгэл хүлээсэн тэргүүн, тухайн газрын удирдагчаас тодруулга авахыг хичээнэ.

Зөв хариулт нь гурав дахь хариулт. Найдвартай эх сурвалжаас мэдээллийг тодруулснаар онлайн орчинд тархсан худал мэдээллийг няцааж чадна. Шашны итгэл хүлээсэн тэргүүн/тухайн газрын удирдагчийг оруулснаар энэ танд итгэлтэй эх сурвалж болоход тусална.

### Үзэгч, уншигчиддаа хүрэх

Зарим газар түүхэн үйл явдлаас шалтгаасан эргэлзээ тээнэгэлзээ ч байна. Мөн цар тахлын үеэр зарим тодорхой бүлэг хүмүүст мэдээлэл тус болохгүй байгаа. Энэ нь тухайлбал вакцины аюулгүй байдал гэх мэт эргэлзээ, тээнэгэлзэл асуудлын тодорхой бус байдлыг өдөөж байж болзошгүй юм. Сэтгүүлчид эдгээр бүлэг, хүмүүстэй өөрсдийн контент, ашигладаг платформоороо дамжуулан харилцахгүй байна.

*Zee News сайтын сурвалжлагч Поожа Макарын бэлтгэсэн сонирхолтой сурвалжлагын цахим холбоосыг энэ тохиолдол жишээ болгож доор оруулсан байгаа. Та бүхэн доор байгаа холбоосоор орж сонирхоорой. Харин бид үе сурвалжлагын орчуулгыг гарын авлагын энэхүү хэсгээр хүргэж байна:*

“Сэтгүүлчийн хувиар аль болох олон хүнд мэдээллээ хүргэхийг хичээх хэрэгтэй. Хэрвээ таны уншигч, үзэгчдэд мэдээлэл хүрэхгүй байгаа бол яагаад тэдэнд мэдээлэл хүрч чадахгүй байна гэдгийг олж мэдэх нь ч гэсэн сэтгүүлч таны үүрэг гэж бодож байна. Яагаад гэвэл миний түрүүний дурдсанчлан цар тахал гэдэг бид бүхэнд

бүгдэд нөлөөлж байна. Жишээ нь вакцинжуулалт, хүн амын дархлааны асуудлын тухайд танай улсын хүн амын зарим нь үүнд хамрагдахгүй байвал энэ нь бидэнд бүх талаараа сөргөөр нөлөөлнө. Энэ талаар мэдэхийг хүссэн олон нийтийн сонирхол маш их байна гэж харж байна. Энэ талаарх мэдээлэл олон нийтэд сонирхолтой болохоор сонирхож байгаа хэрэг биш харин эрүүл мэндийн холбогдолтой мэдээлэл хомс, учир дутагдалтай байгаа учраас олон нийт энэ тухай мэдээллийг сонирхож байна. Учир нь энэ асуудал бидэнд бүгдэд маань нөлөөлөх учраас тэр. Энэ бол халдварт өвчин шүү дээ. Та хаана амьдардаг, аль газар орон нутгийнх, хэдэн настай гэдгээс үл хамаарч хүн бүр энэ өвчнийг тараана. Тиймээс бид хамтдаа хүчин зүтгэж, мэдээллийг бүх хүнд хүргэхийг хичээх нь хамгийн чухал. Би ажлаа энэ талаас нь ойлгож маш нухацтай ханддаг. Сэтгүүлч бидний хувьд аль болох олон хүнд оновчтой, баримттай мэдээлэл хүргэхийг хичээх нь юу юунаас илүү онцгой чухал юм.”

### **Үзэгч, уншигчидтайгаа харилцах, хүрч ажиллах**

Сэтгүүлч нь:

- Бүх нэгж, баг дүүрэг, сум хороо гээд нийгмийн бүх гишүүдэд асуудлыг ойлгоход нь тусалж, тэдний асуултад хариулт өгөх
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон тэдний ашигладаг платформоор нь дамжуулан тэдэнтэй ярилцах
- Тухайн сум дүүрэг, баг хороо, хэсэг бүлэг хүмүүст хамаатай буюу нөлөөтэй хүмүүсийн дуу хоолойг ашиглах

### **Кейс судалгаа:**

Олон хэвлэл мэдээллийн байгууллага вакцинжуулалтын хөтөлбөрийн талаар алдартнууд эсвэл нэр хүндтэй хүмүүсийн вакцин тариулж байгаа талаар мэдээлэх замаар дүрсэлсэн байдаг. Энэтхэгийн Zee News мэдээллийн байгууллагын эрүүл мэндийн сурвалжлагч Поожа Макар өөрийнхөө вакцин хийлгэсэн туршлагынхаа тухай сурвалжлан хүргэсэн. Тэрээр Коваксин вакцины 3-р шатны туршилтыг

дуусаагүй, нийтийн дунд эргэлзээ ихтэй байх тэр үед энэ талаар ийнхүү мэдээлж байв.

<https://zeenews.india.com/india/zee-news-reporter-pooja-makkar-becomes-first-indian-woman-journalist-to-get-covaxin-vaccine-2334253.html>

### **Вакцины талаарх ойлголт – шинжлэх ухаан ба үйлдвэрлэл**

Сэтгүүлчид бид вакцины талаарх эргэлзээний цаад шалтгааныг ойлгох нь чухал. КОВИД-19 цар тахлын үед хамгийн их анхаарал татсан зүйлсийн нэг бол вакцин үйлдвэрлэх хурд байв. Хурдан батлах хэд хэдэн шалтгаан бий:

- Зарим вакцинууд нь аль хэдийн нэлээд боловсронгуй болсон туршилтууд дээр тулгуурлан хийгдэж байв.
- Ердийн үед судлаачид вакцин дээр ажиллахын тулд ихэнхдээ маш олон төрлийн санхүүжилтийн өргөдөл гаргах үе шатыг дамжих шаардлагатай болдог. Харин цар тахал санхүүжилтийн асуудлыг хурдтайгаар шийдэгдэх нөхцөлийг бий болгосон.

Ердийн үед анагаахын судалгаанд тулгардаг олон саад бэрхшээлийг цар тахлын үед хэрэгсэхгүй болгосон боловч энэ нь зохих аюулгүй байдлын шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэх талаарх эргэлзээ, санаа зовинолыг бий болгосон байх талтай.

### **Дасгал: Үзэгч, уншигчидтайгаа харилцах, хүрч ажиллах**

Судалгааны болон вакцины зөвшөөрөл олгох нарийн төвөгтэй явцын талаар уншигч, сонсогч, үзэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй, мэдээлэлтэйгээр хүргэх гэдэг сэтгүүлч бүрийн хувьд томоохон сорилт болдог.

Шууд мэдээний хэлбэрээр мэдээлэхээс гадна ямар хэлбэр, арга техникээр хүргэж болох вэ? Санал бодлоо бичнэ үү.

Бид бодож олсон цөөн санааг энд оруулав.

### 1. Видео тайлбар

Цар тахлын үеийн вакцины шуурхай зөвшөөрлийн учир шалтгааныг вебсайт, сошиал медиа, өргөн нэвтрүүлгийн платформ зэргээр дамжуулан богино хэмжээний видеогоор тайлбарлах

BBC-н бэлтгэсэн дараах видео сайн жишээнүүдийн нэг юм: КОВИД-н вакцин хэрхэн зөвшөөрөгддөг вэ? <https://www.bbc.co.uk/news/av/health-55281633>

### 2. Асуулт, хариулт

Энэ нь уншигчдад товчхон унших/лавлах материал болно. Энэ хэлбэрийн мэдээллийг олон аргаар бүтээх боломжтой.

- Уншигчид, үзэгчдийн асуултанд хариулах хэлбэрээр
- Вакцин үйлдвэрлэхэд оролцсон анагаах ухааны судлаачтай хийх асуулт, хариулт
- Эмийн зохицуулагчтай хийх асуулт, хариулт. Энэ мэтчилэн хязгааргүй их жагсаалт байж болно.

### 3. Жагсаалт үүсгэж тайлбарлах

Асуулт, хариултын хэлбэртэй төстэй боловч гол санаанууд дээр төвлөрч, тэдгээрийг асуултын хэлбэрт оруулан нэг бүрчлэн мэдээлэл бүхий тайлбартайгаар мэдээлэх арга юм. Guardian-ий "Амар хялбар зүйлийг эрж хайлгүйгээр КОВИД-19-н вакциныг маш хурдан хийлгэсэн арван шалтгаан" (Ten Reasons we got Covid-19 vaccine so quickly without 'cutting corners') нийтлэл энэ аргын нэг жишээ юм.

<https://www.theguardian.com/commentisfree/2020/dec/26/ten-reasons-we-got-covid-19-vaccines-so-quickly-without-cutting-corners>

#### 4. Подкаст

Хэлэлцүүлэг, үзэл бодол, анализ мэдээлэл хийхдээ подкастыг мартаж болохгүй. Их Британийн Засгийн газрын бүтээсэн подкастын жишээг дараах холбоосоор сонирхоно уу.

<https://podcasts.apple.com/gb/podcast/covid-19-the-search-for-a-vaccine/id1527299221>

Өөрийн бэлтгэсэн контентаа аль болох мэргэжлийн, ойлгомжгүй үг хэллэгээс зайлсхийсэн олон хэлбэрээр, оновчтой хүртээмжтэй байдлаар хүргэх нь чухал юм.

#### Кейс судалгаа: Энэтхэг дэх вакцины талаарх эргэлзээ

Капил Кажал бол Энэтхэгт төвтэй The Federal нэртэй дижитал мэдээллийн платформ дээр ажилладаг сэтгүүлч юм.

<https://thefederal.com/news/doctors-in-delhi-haryana-shun-covaxin-say-well-take-covishield-or-wait/>

2021 оны 1-р сард тэрээр эмч, эрүүл мэндийн ажилчдын тариулж буй вакцинтай холбоотой эргэлзээтэй асуудлын талаар мэдээлж байсан. Асуудал нь Коваксины 3-р шатны туршилт дуусаагүй байсан ба хүмүүс зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурах ёстой байв. Эрүүл мэндийн салбарын ажилчид хүн амын вакцинжуулалтаас түрүүлж вакцинд хамрагдаж байв.

Тэрбээр нийтлэлдээ хэрвээ вакцин аюулгүй юм бол яагаад зөвшөөрөл олгох хуудас хэрэгтэй вэ гэх мэт асуултуудыг тусгасан.

**Капил Кажал: Хүмүүстэй ярилц:** Хүмүүсийг сурвалжилгандаа итгэлтэй байлгахын тулд би олон хүнтэй ярилцах хэрэгтэй болсон. Сэтгүүл зүйд ярьдаг эх сурвалжийн гурван түвшинг хангахтай адилхан би сурвалжлагадаа тэнцвэртэй байдлыг хадгалах ёстой. КОВИД-н вакцины талаарх сурвалжлагадаа засгийн газар юу ярьж байгааг, эмч нар юу хэлж, юу хийх хэрэгтэй гэж байгаа талаар дурдсан. Би нийтлэлийнхээ ерөнхий агуулгаар үндсэн мэдээллийг өгөх, дүр зургийг харуулахыг хичээсэн. Мөн би нийтлэлдээ хүн бүр, дурын хэн нэгэн хайгаад олж болохуйц ядаж нэг албан ёсны эх сурвалж нэмэхийг чармайсан. Ингэснээр хүмүүс нийтлэлээс өөрт хамаатай, хамааралтай зүйлийг олох болно. Яг одоогоор Энэтхэгт вакцины талаар шинжлэх ухааны мэдээлэл, харилцаа дутмаг байгаагаас үүдэн вакцины талаарх эргэлзээтэй асуудал, санаа зовинол их байна. Тиймээс би мэргэжилтнээс мэдээлэл авах биш байдлыг дүрсэлсэн суурь мэдээллийг харуулахыг зорьсон. Учир нь вакциныг дэмждэггүй эсвэл дэмждэг мэргэжилтнүүд байх талтай юм.

### **Капильн зөвлөгөө: Өөрийнхөө улсын тухай судалж мэдэх**

Капил Энэтхэгийн улс төр, бизнесийн ерөнхий байдлын талаархи мэдлэгтээ үндэслэн эрдэмтэд, улстөрчидтэй ярилцах нь чухлаас гадна яг газар дээр нь ажиллаж, амьдарч буй хүмүүсийг оруулах нь чухал гэдгийг мэддэг. Улс төрийнхөн бол аливаа анагаахын нээлт, ололтыг өөрсдөдөө хамаатуулах сонирхолтой байх нь бий. Жишээ нь эмнэлэгийн ажилчид гэх мэт хүмүүсийг оролцуулах.

### **Цуу яриаг илрүүлж, “хуйвалдааны онол”-ын тухай хэзээ мэдээлэх вэ?**

Өмнөх дуулиан шуугианууд дээр тулгуурлан бид "вакцины талаарх эргэлзээ"-ний байж болох учир шалтгааныг судалж үзсэн. Анагаах ухаанд итгэх итгэлгүй байдал, мөн зарим тодорхой газар нутаг, бүлгийн хүмүүсийн хувьд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцдах, мэдээлэл авах байдал дутмаг байв. Харин бодит бус мэдээлэл байвал яах вэ? Худал мэдээлэл, хуйвалдааны онолчидтой хэрхэн тэмцэх вэ?

### Бодит бус мэдээллийг ерөнхийдөө гурван ангилалд хуваана:

- Disinformation (Хуурамч мэдээлэл) – Хүмүүс мөнгө олох зорилгоор, улс төрийн нөлөөлөл олж авах зорилгоор эсвэл бусдад төвөг учруулж, бусдыг хохироож, гэмтээх зорилгоор санаатайгаар үүсгэсэн хуурамч эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл
- Misinformation (Худал мэдээлэл) – Хуурамч мэдээллийг худал эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл гэдгийг нь мэдэхгүйгээр бусадтай хуваалцсан мэдээлэл. Ихэвчлэн хүмүүс бусдад туслах зорилгоор мэдээлэл хуваалцах нь бий.
- Хөнөөлтэй мэдээлэл (Malinformation) – Бусдад хор хөнөөл учруулах зорилгоор тараасан жинхэнэ мэдээлэл. Тухайлбал, хэн нэгний хувийн мэдээлэл гэх мэт.

Ихэнх худал болон хуурамч мэдээлэл социал медиагаар дамжих нь түгээмэл ба бидний ихэнхи нь тэндээс мэдээлэл хайж үздэг.

Сэтгүүлч хүний хувьд мэдээлэл тарааж буй хүний талаарх ерөнхий мэдээллийг харж, энэ мэдээлэл хаанаас гарч ирснийг олж мэдэх нь чухал юм.

### Вакцин эсэргүүцэгчид: Хувийн үзэл бодол

*“Би мөнхийн хөдөлгөөнт машинд итгэдэг хүнээс ярилцлага авахгүй. Яагаад гэвэл би өмнө нь физикч байсан ба энергийн талаас авч үзвэл мөнхийн хөдөлгөөнт машин нь боломжгүй зүйл. Мөн би вакцины эсрэг санаа бодлын тухай үзүүлэхгүй байхыг чухалчилдаг. Учир нь хэдийгээр энэ санааг няцаагаад өгнө дөө гэж бодсон байсан ч гэсэн үүний тухай мэдээлэх нь өөрөө уг асуудлыг эш татан дурдаж, хүлээн зөвшөөрч байгаа хэрэг болно. Энэ асуудалд ингэж таатай байдал үүсгэх ёсгүй.” хэмээн Анжана Ахужа ярьж байна.*



Тэрээр Financial Times сэтгүүлийн сэтгүүлч бөгөөд шинжлэх ухааны мэргэжлээр суралцсан болохоор шинжлэх ухааны дүрэмтэй зөрчилдсөн онол ярьдаг хүмүүсээс ярилцлага авдаггүй. Анжана вакцины эсрэг үзэл санааны талаар мэдээлэх нь хүлээн зөвшөөрч буй үйлдэл болчих вий хэмээн эмээдэг тул ийм үзэл санааны талаар нарийн мэдээлэхдээ “хязгаар” тавихаар шийдсэн.

### Би хэзээ “хуйвалдааны онол”-ын тухай сурвалжлах вэ?

Сэтгүүлчид вакцины талаарх худал мэдээллийн тухай баримт, тоон мэдээлэлд тулгуурлан мэдээлэх боломжтой. Харин "муу тоглогчид"-ын хувьд? Вакцин эсэргүүцэгчид өөрсдийнхөө зорилгын төлөө зорилготойгоор хуурамч мэдээлэл хүргэж байвал? Тэдэнд мэдээллээ түгээх платформ өгснөөр цуу яриаг дахин давтах, үргэлжлүүлэх эрсдэлтэй.

Хамгийн алдартай "хуйвалдааны онол"-ын нэг бол КОВИД-19 вакцинд микрочип байгаа бөгөөд таны хөдөлгөөн ул мөрийг мөшгих боломжтой гэх мэдээлэл юм. 2020 оны 5-р сард ганцхан өдөр ТикТокын нэг видеог Facebook дээр 22800 удаа хуваалцсан байдаг. АНУ-ын NBC News сувгийн бодит мэдээний зураг авалтын видеог агуулгатай нь хамааралгүйгээр таслан авч худлаа текст нааж мэдээлсэн байв.

<https://www.reuters.com/article/uk-factcheck-video-microchip-coronavirus/false-claim-a-microchip-implant-will-come-with-coronavirus-vaccines-idUSKBN22R2GS>

Баримт нягтлан шалгагчид (fact checker) энэхүү мэдээллийг илрүүлсэн. Гэхдээ ямар ч хачир чимэггүй тэдний ажил үзэгч, уншигчдад хүрэхгүй байх нь бий. Тиймээс баримтыг нягтлан шалгахаас гадна олон сэтгүүлчид эдгээр хуйвалдааны онол нь хүмүүсийн амьдралд ямар нөлөөлөл учруулж байгаа тухай хүн төвтэй мэдээлэл хүргэж байна.

**Асуулт** [зөв хариулт b]

Танай улсын тэргүүлэх вакцин эсэргүүцэгчдийн нэг нь 20-н насны хоёр хүүтэй нэгэн ээж юм. Хүү нь түүнтэй санал нийлдэггүй. Тэр ээж цар тахлын үеэр хуйвалдааны онолыг түгээдэг гэдгээрээ алдартай болсон. Вакцин эсэргүүцэгчдийн жагсаалд тогтмол оролцох болсон ба YouTube дээр 40000 дагагчтай. Дагагчдын тоо улам нэмэгдэж байна. Редактор тань түүний тухай мэдээлэл хийхийг хүсч байна. Та хэрхэн мэдээлэх вэ?:

- a. Түүнээс амьдардаг хотдоо хүмүүст тараах материал тарааж буй талаар нь ярилцлага хийнэ. Зураглал сайн байх болно. Ингэснээр түүний үзэл бодолд сорилт үүсгэх ашигтай тал бий.
- b. Түүний хүүхдүүдийн нэгтэй нь ярилцлага хийж, ээжийнх нь талаар болон түүний сурталчилгааны кампанит ажил гэр бүлийнх нь амьдрал, цар тахалд хэрхэн нөлөөлсөн талаар тодруулж ярилцана.
- c. Түүнтэй гэрт нь ярилцлага хийнэ. Кампанит ажлын цаана ямар эмэгтэй байдгыг харуулах давуу талтай.
- d. Түүнтэй ярилцлага хийх боловч түүний санаанд эсрэг аргумент дэвшүүлэх хэн нэгнийг бас заавал нийтлэл/нэвтрүүлэгтээ оруулна.

BBC үүнийг хэрхэн мэдээлснийг эндээс сонирхоно уу:

<https://www.facebook.com/bbcnews/videos/2970765306357017>

### Сэтгэл хөдлөл ба айдас

Хуурамч мэдээлэл нь сэтгэл хөдлөл, айдас дээр тоглодог. Сэтгүүлч хүний хувьд та "хуйвалдааны онол"-ыг няцаах баримтыг гаргаж үзүүлсэн ч тэр айдас хэвээр үлдэх талтай.

Энэтхэгт 2021 оны 1-р сард вакцины хөтөлбөрийг нэвтрүүлэхээс өмнө вакцин нь хүмүүсийг үргүйдэлд хүргэж болзошгүй гэсэн цуурхал сошиал медиад цацагдаж байсан. Times of India сонинд Эрүүл мэндийн сайдын үүний талаарх няцаалтыг эш татсан нийтлэл гарсан боловч цуурхал хэвээр байна.

<https://timesofindia.indiatimes.com/india/can-covid-vaccine-cause-infertility-health-minister-busts-myths/articleshow/80272246.cms>

### Асуулт [зөв хариулт b]

Сэтгүүлч уншигч, үзэгчдэдтэй илүү их харилцаа үүсгэх, хүртээмжтэй ямар нэмэлт нийтлэл, мэдээлэл хийж болох вэ?

- a. Үргүйдлийг үгүйсгэсэн сайдын няцаалтыг дэмжих нэмэлт эшлэл, мэдээлэл авахаар эмийн компанитай холбоо барих
- b. Уншигч, үзэгчдэд тулгамдаж буй асуудлыг тэднээс ярилцлага авах замаар ойлгож, тэднийг айлгаж буй зүйлсийн талаар хүртээмжтэй хэлбэр, ойлгомжтой үг хэллэг, хэлээр хариулах
- c. КОВИД-19-н улмаас хамаатан саднаа алдсан гэр бүлээс ярилцлага авч нийтлэл мэдээллээ илүү хүн төвтэй болгон, үр дагаварын тухай үзүүлэх

### Дүгнэлт

Цар тахал, вакциныг тойрсон мэдээллийн үерийн дундуур хэрхэн мэдээлэлтэй, оролцоотой, төөрөгдүүлээгүй, хуурамч мэдээллийг дэвэргээгүй контент үйлдвэрлэх вэ гэдэг тийм ч амар зүйл биш. Гэхдээ таныг чиглүүлэх хэд хэдэн зүйлс бий:

- Мэдээллээ нэг бүрчлэн нягталж шалгах
- Хүмүүсийн айдас, түгшүүрийг ойлгох
- Хүмүүсийн айдсын талаар дурдаж, хэлэлцэж, контентоо хүн төвтэй болгох
- Вакцин эсэргүүцэгчдийн хуйвалдааны онолын үр дагаврыг харуулж контентоо хүн төвтэй болгох

Дараагийн хэсэгт бид төөрөгдөл, худал, хуурамч мэдээлэлд өртөмтгий хэсгийг авч үзэх болно. КОВИД-19-р өвчилсөн хүмүүст зориулсан эмчилгээ.

Нягтлан баталгаажуулах талаархи дэлгэрэнгүй мэдээллийг манай “КОВИД-19-ын тухай мэдээлэх: Нягтлан баталгаажуулах” (Covering Covid-19: Verification) үнэгүй хичээлээс үзнэ үү.

<https://thomsonfoundation.edcastcloud.com/learn/covering-covid-19-verification-self-paced>

### Санал дүгнэлт

Санал дүгнэлтээ үлдээнэ үү. Асуулт тус бүрийг 1-5 хүртэлх оноогоор дүгнэнэ үү.

1 – огт үгүй, 5 – маш их

Хичээлийг үзэж дуусахад хэр хугацаа зарцуулсан бэ? (Ойролцоо цагаар илэрхийлнэ үү)

Хичээл ойлгомжтой, мэдээлэлтэй байсан уу?

Хичээл таны ажилд, карьерт хэрэгтэй байсан уу?

Хичээл танд таалагдсан уу?

Эх сурвалж:

[Thomson Foundation | Томсон сан](#)

[Reporting on COVID-19: Vaccines |](#)

## ЗУРГАА. КОВИД-19 ВАКЦИНЫ ТАЛААРХ ЭРГЭЛЗЭЭГ МЭДЭЭЛЭХЭД АНХААРАХ ЗУРГААН ЗӨВЛӨМЖ

---

2019 онд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас вакцины талаарх эргэлзээ нь дэлхий дахины эрүүл мэндэд заналхийлж буй 10 аюулын нэгд оруулсан байна. Тиймээс сэтгүүлчид энэ асуудлын талаар олон нийтэд мэдээлэл түгээж, асуудлыг гэрэл гэгээтэй болгох нь чухал юм. /Бичсэн [Naseem S. Miller](#) | 2021 оны 2-р сарын 9/

Америкчуудын КОВИД-19-н вакцины талаархи сонирхол нэмэгдэж байна. Kaiser Family Foundation-ны саяхны санал асуулгаар 1-р сард насанд хүрэгчдийн арван хүн тутмын дөрвөөс илүү нь вакциныг үнэгүй тариулах боломжтой үед тариулна гэж хариулсан бол 12-р сард энэ үзүүлэлт 34%-тай байжээ.

Мөн "Хүлээж байна, вакцин ямархуу үр нөлөөтэй байхыг ажиглахыг хүсч байна" гэсэн насанд хүрэгчдийн тоо 12-р сараас 1-р сарын хооронд 39%-иас 31% болж буурсан гэж KFF санал асуулгаар гарчээ. Түүнчлэн "гарцаагүй шаардлага гарсан үед тариулна", "огт тариулахгүй" гэж хариулсан насанд хүрэгчдийн тоо ялимгүй буурсан байна.

Хэдий олон америкчууд КОВИД-19 вакцины талаар ойлгож хүлээн авч байгаа ч цар тахлын өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр төдийлөн сайн мэдээлэл аваагүй хүн амын нэг хэсэг буйг онцолжээ: вакцины талаар эргэлзэж буй хувь хүмүүс. ДЭМБ-аас вакцины талаарх эргэлзэж байгаа буюу "вакцин тарих үйлчилгээ боломжтой байхад тариулахаа хойшлуулах, тариулахаас татгалзах" байдалд "бардамнал, ая тухтай байдал, өөртөө итгэх итгэл зэрэг хүчин зүйл нөлөөлдөг" гэж тайлбарлав.

2019 онд ДЭМБ-аас вакцины талаарх эргэлзээ нь дэлхий дахины эрүүл мэндэд заналхийлж буй 10 аюулын нэгд орж байгааг дурджээ. Тиймээс сэтгүүлчид энэ асуудлын талаар олон нийтэд мэдээлэл түгээж, асуудлыг гэрэл гэгээтэй болгох нь чухал. Гэхдээ вакцины талаар эргэлзэж буй хүмүүсийг вакцин эсэргүүцэгчид гэх цөөн тооны боловч маш идэвхитэй нөлөөллийн ажил явуулж буй хүмүүсээс ялгах нь чухал.

*Нью-Йорк Таймс сонинд вакцин ба вакцины талаарх эргэлзээний тухай бичсэн шинжлэх ухааны сэтгүүлч Мелинда Веннер Мойер “Вакцин эсэргүүцэгчид бол вакцины талаар эргэлзэж буй хүмүүсээс ялгаатай” гэж хэлжээ.*

Тэрээр вакцин эсэргүүцэгчдийг “цөхрөлтгүй худал мэдээлэл тарааж, бусад хүмүүст вакцин аюулгүй биш гэж итгүүлэхийг оролддог хүмүүс” гэж тодорхойлжээ. Гэхдээ бүх хүн ийм биш. Ихэнх хүмүүс нэг эргэлзээтэй асуулттай, тэр асуултандаа хариулт авталаа эргэлзсэн байдалтай байдаг.

Оршин суугаа газрынхаа вакцины талаарх эргэлзээг судалж, уншигчдад түүний учрыг тайлбарлах ажилд цаг гарга.

*“Вакцины талаар эргэлзэж буй хүмүүс маш олон төрлийн хүмүүс байдаг” гэж шинжлэх ухааны ахмад сэтгүүлч, зохиолч, Эмори Их сургуулийн Хүний эрүүл мэндийн судалгааны төвийн ахлах мэргэжилтэн Мэрин Маккенна хэлэв.*

“Вакцины талаарх эргэлзээ, тээнэгэлзэл нь ганцхан зүйл биш, энэ нь спектр буюу өргөн асуудал гэдгийг уншигч эсвэл үзэгчдэд ойлгуулахыг хичээ. Хүмүүсийн итгэх, үл итгэх түвшин янз бүрийн шалтгаанаар өөр өөр байдаг.”

Бид хэд хэдэн судлаач, сэтгүүлчдээс вакцины талаар эргэлзээтэй асуудлыг сурвалжлагчид хэрхэн сурвалжлах нь зүйтэй талаар тодруулав. Тэдний зөвлөгөөг зургаан зөвлөмжид нэгтгэн хүргэж байна.

## 1. Тухайн газарт хэн эсвэл ямар бүлэг хүмүүс вакцины талаар эргэлзэж байгааг олж мэдэх

*"Тухайн газар вакцины талаар эргэлзээ, тээнэгэлзэлтэй гэж, мөн тэд яагаад вакцины талаар эргэлздэг тухай өөрийнхөөрөө бүү таамагла. Вакцины талаар хэн юу мэдэж байгааг таамаглаж нийтлэл бүтээлээ хийж болохгүй" гэж доктор Эмили Харрисон хэлэв.*

Тэрээр Харвардын Нийгмийн эрүүл мэндийн Т.Х Чанийн сургууль болон Харвардын шинжлэх ухааны түүхийн тэнхимийн докторын дараах сургалтын судлаач (the Harvard T.H. Chan School of Public Health and Harvard History of Science Department) бөгөөд өнгөрсөн дөрөвдүгээр сард Европын эпидемиологийн сэтгүүлд хэвлэгдсэн "КОВИД-19-н үеийн вакцинд итгэх итгэлцэл" эссегийн хамтран зохиогч юм. "Вакцины талаар хэн юу мэдэрч байгааг мэдэж байна гэж таамаглаж үлгэр ярьж болохгүй."

## 2. Бусдад хүндэтгэлтэй хандаж, үзэгч, сонсогч, уншигчдынхаа вакцины талаар асуултад хариул

*"Хүмүүс [КОВИД-19] вакцины талаар, ялангуяа шинэ вакцины талаар асуулт, эргэлзээтэй байх нь ойлгомжтой. Сэтгүүлчид бид үүнд хүндэтгэлтэй хандах ёстой" гэж Мойер хэлэв.*

Олон нийтэд асуулт асуух боломж олго. Та асуултуудаа цуглуулж болох ч сошиал медиа сувгууд эсвэл мэдээллийн вебсайт дээрээ тухайн сэдэвтэй асуулт авч байгаагаа зарлаж болно. Орон нутгийн эмч, сувилагчдаасаа өвчтөнүүд ямар асуултууд асууж байгааг лавлаж, тэдгээр асуултыг нийтлэл, бүтээлдээ оруулж болно.

*"Хэрэв бид олон нийтэд асуулт асуух боломж олгохгүй бол тэдний юу асуухыг хүсч байгааг мэдэхгүй, таамаглал л дэвшүүлэх болно" гэж Флоридагийн Их сургуулийн эпидемиологийн дэд профессор, доктор Синди Принс хэлэв.*

Хавдар судлалын үндэсний хүрээлэнгийн Эрүүл мэндийн харилцаа холбоо, мэдээлэл зүйн судалгааны салбарын хөтөлбөрийн захирал, эрүүл мэндийн харилцаа холбооны салбарт 10-р сард хэвлэгдсэн "КОВИД-19 вакцины харилцаанд сэтгэл хөдлөлийг харгалзан үзэх нь" судалгааны ажлын хамтран зохиогч доктор Вэн-Ин Силвиа Чоу тухайн газар нутгийн алдартай хүмүүс, тухайлбал тамирчин, олон нийтийн идэвхтэн, удирдагчид асуулт асууж, мэргэжилтнүүд хариулахыг зөвлөж байна. Сэтгүүлчдийн хувьд энэ нь тухайн газар, нутгийнхаа мэргэжилтэн, удирдагчидтай хамт виртуал форум үүсгэх боломж байж болох юм.

### **3. КОВИД-19-н вакцины гаж нөлөөг хэтрүүлэн тодотгох хэрэггүй. Вакцины талаар хараахан мэдэгдээгүй байгаа зүйлсийг дурд.**

"Бид [вакцины] талаар үнэн зөв, бодитоор мэдээлэх ёстой" гэж Маккенна хэлэв. "Бид гаж нөлөөний талаар мэдээлж, тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хүмүүст яг тодорхой мэдээлэх ёстой. Ингэснээр гаж нөлөөний талаархи аливаа мэдээлэл хэмжээнээсээ хэтрэхгүй байх болно."

*КОВИД-19-н вакцины гаж нөлөөг тайлбарла – хүн амын ихэнхи нь КОВИД-19-р хүнд өвчлөөд, эмнэлэгт хэвтэж байгаатай харьцуулахад вакцины гаж нөлөө нь маш бага гэдгийг тайлбарла гэж Принс ярьж байна.*

"Түүнчлэн [КОВИД вакцин]-ыг шуурхай журмаар хянан гаргаж байгаа нь аливаа хийх ёстой алхамыг алгасаж, хялбарчилсан гэсэн үг биш юм" хэмээн Эрүүл мэндийн үндэсний хүрээлэнгийн нийгмийн эрүүл мэндийн талаархи КОВИД-19



вакцинжуулалтын харилцааны гарын авлагыг бичихэд тусласан Чоу хэлж байна. Мөн тэрээр "Бид одоо ч гэсэн олон зүйлийг мэдэж авч байна. Эрүүл мэндийн үндэсний хүрээлэн урт хугацааны үр дагавар, гаж нөлөөг ажиглахад маш их хөрөнгө оруулалт хийсэн. Ашиг тус нь эрсдлээс илүү байдаг. Бид бүх зүйлийг хүмүүст үнэнээр тайлбарлах хэрэгтэй бөгөөд яг одоогоор бидэнд байгаа хамгийн сайн шийдэл гэдгийг хүмүүст хэлэх хэрэгтэй" хэмээн нэмж хэлэв.

#### 4. Нийтлэл, бүтээлдээ эх сурвалжийн түвшингийн тэнцвэрийг ханга.

Вакцины талаархи таны бэлтгэсэн мэдээлэл нь олон нийтэд бусад хүмүүс энэ талаар ямар сэтгэгдэлтэй байгааг үнэлэх боломжийг олгоно. Хэдийгээр санал асуулгын дүнгээс ялгаатайгаар хэрэв та зөвхөн вакцин хийлгэхгүй гэсэн хүмүүсээс ярилцлага авах юм бол санамсаргүй байдлаар тодорхой бүлэг хүмүүс эсвэл нийгмийн ихэнх нь вакцин хийлгэх талаар эргэлзэж байгаа мэтээр харуулах болно. АНУ-ын Хүн амын тооллогын товчооноос 1-р сарын 27-нд КОВИД-19-н вакцин хийлгээгүй байгаа америкчуудын 51% нь вакцин хийлгэхээр төлөвлөж байна гэсэн бол, ахиад 26% нь вакцин хийлгэх магадлалтай гэж хариулсныг мэдээлжээ. Вакцин хийлгэсэн эсвэл хийлгэхээр төлөвлөж байгаа хүмүүстэй заавал ярилцах хэрэгтэй. "Ганцхан талаас нь биш олон талаас нь асуудлыг харах" гэж Принс зөвлөж байна.

*Хэрэв таны нийтлэл, бүтээлд хугацаа хангалттай байгаа бол өмнө нь вакцины талаар эргэлзэж байгаад, бодлоо өөрчилж, вакцин хийлгэсэн хүмүүсийг хайж олоорой гэж тэр нэмж хэлэв.*

Харрисоноос өгсөн зөвлөмж: Вакцин хийлгэж байгаа хүмүүсээс яагаад вакцин хийлгэхээр шийдсэн, ямар хүчин зүйлсээс хамаарч вакцинд хамрагдах итгэлтэй болсныг асуу.

**5. Оршин суугчдын дийлэнх нь арьсны өнгөөр ялгаварлан гадуурхдаг эсвэл үндэстний цөөнх амьдардаг газруудад вакцинжуулалтын түвшин яагаад буурах хандлагатай байгааг ойлгохын тулд тэнд цаг зарцуул.**

Саяхны олон нийтийн дунд явуулсан санал асуулгаар хар, испани гаралтай насанд хүрэгчид вакцины асуудлаар цагаан арьстнуудаас илүү болгоомжилдог гэж гарчээ. Үүнтэй ижил дүр зураг хөдөө орон нутгийн оршин суугчдын хувьд ч ажиглагдаж байна. Судлаачид, сэтгүүлчид системийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэгдэл болон анагаах ухааны нийгэмлэгт итгэх итгэл харьцангуй дутагдалтай байгаа асуудал хоёрын уялдаа холбоог судлав. Жишээлбэл, 11-р сард Wired дээр гарсан нийтлэлд МкКенна анагаах ухааны арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн түүхийг судалж үзсэн нь өнгөт арьстнуудын дунд вакцины талаарх эргэлзээг төрүүлэхэд хөтөлсөн гэжээ. Хоёрдугаар сард Лос Анжелес Таймс сонинд хэвлэгдсэн өгүүлэлд сурвалжлагч Куртис Ли хэрхэн Тускигийн тэмбүүгийн судалгаа хар арьстнуудын дунд вакцины талаарх эргэлзээ төрүүлэхэд хүргэснийг тайлбарлажээ. Гэхдээ зарим газарт вакцинжуулалтын хувь бага байгаагийн ганц шалтгаан нь вакцины талаарх эргэлзээ биш юм.

*"Зарим нь вакцинжуулалтын түвшин бага байгаагийн шалтгааныг хүмүүс вакцин хийлгэхээр шийдэхгүй байгаатай холбоотой гэж таамаглаж болох юм" гэж Харрисон хэлэв.*

“Гэхдээ вакцинжуулалтыг түвшинд зарим талаараа хүртээмжтэй байдал нөлөөлж байх талтай. Магадгүй энэ нь системийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэгдлийн нөлөө мөн вакцин тариулах нь хэнд хүртээмжтэй байна вэ гэсэн асуудлуудын нөлөө ч байж болно. Статистик мэдээлэл асуулт асуух боломжийг үүсгэж байна.”

Өнгөт арьстнуудын дунд олон хүн вакцинд хамрагдах хүсэлтэй байгааг ч мөн сэтгүүлчид онцлох хэрэгтэй. Жишээлбэл, АНУ-ын Хүн амын тооллогын товчооноос 1-р сард явуулсан судалгаагаар хар арьст хүмүүсийн 22% нь вакцин хийлгэхгүй байх гэж хариулсан бол 64 орчим хувь нь вакцин “гарцаагүй” эсвэл “магадгүй хийлгэх болно” гэж хариулжээ.

Гэр бүл, хамт олноо цар тахал өвчнөөс хамгаалахын тулд шаргуу ажиллаж байгаа хүмүүсийн жишээг хайж олохыг зорь хэмээн Др. Рид Таксон зөвлөж байна. Др. Рид Таксон бол КОВИД-19-тэй тэмцэх хар эвслийн хамтарсан зөвлөх бөгөөд үндэсний эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, мэргэжлийн хүмүүсийн нэгдэл КОВИД-19 ба вакцины талаархи мэдээллийг хар арьстнуудад хүргэх, итгэлцэл төрүүлэхийг зорьж байна.

*"Өөрөө вакцинд хамрагдах боломжгүй боловч хар арьст гэр бүлийн үнэ цэнийг эрхэмлэн эмээгээ вакцин хийлгэхээр авч ирсэн залуу хүний тухай түүхийг ярь" гэж Таксон хэлэв. "Бид энэ талаар Хар арьстнуудын призм болон амьд оршин тогтнохын төлөөх харилцааны талаар илүү ихийг өгүүлэх ёстой. Бид амьд оршин тогтнохын төлөөх түүхийг өгүүлэх хэрэгтэй гэж бодож байна."*

Тэрээр мөн нийтлэлдээ орон нутгийн идэвхтнүүдийг оролцуулахыг зөвлөж байна. “Хар хүний амьдрал үнэ цэнтэй. Вакцинжуулалт тэдэнд хүртээмжтэй байх байдлыг хангах ёстой гэж ярьдаг Black Lives Matter хөдөлгөөний идэвхтэн хэн нэгнийг ол” гэж Таксон зөвлөж байна. “Орон нутгийн түвшинд тэгш хүртээмжийн төлөө тэмцэж байгаа хүмүүсийн талаар илүү их түүх ярьж өгүүлэх хэрэгтэй.”

## **6. Вакцины талаарх эргэлзээтэй байдлыг судалдаг судлаач, эрдэмтэдтэй ярилц.**

Шинжлэх ухааны сэтгүүлч Тара Хаэлл вакцины талаар их бичдэг ба Эрүүл мэндийн сэтгүүлчдийн нийгэмлэгийн вебсайтын блог дээрээ вакцины эргэлзээтэй байдлын

талаархи судалж үзсэн судалгаануудын жагсаалтыг оруулсан байна. Судалгааны ажлын зохиогчидтой холбогдож тайлбар, зөвлөгөө аваарай. "Мөн олон хүнтэй ярилцаж, өөр өөр өнцгөөс харж, дараа нь нийтлэг ерөнхий санаа төлөвийг хайж олох хэрэгтэй" гэж Принс хэллээ.

*Шинжээчдээс өөр эх сурвалж, түүний дотор өөр өнцгөөс харж болох эх сурвалжийг санал болгохыг хүс. Ажлаа давхар шалгаж үзээрэй. "Мэргэжилтнүүдээс асууж тодруулах нь бидний хувьд албан ёсны үүрэг юм" гэж МкКенна хэлэв. "Бид буруу, зөв эсэх, тоон мэдээллийг буруу тайлбарласан эсэхийг хэлж чадах албан бус баримтыг шалгагчдыг хайж олох хэрэгтэй. Ингэснээр мэдээлэл аль болох оновчтой бодит байх болно."*

## ДОЛОО. COVID-19 ВАКЦИНЫ ТАЛААР ТҮГЭЭМЭЛ

### АСУУЛТ ХАРИУЛТ

---

#### 1. Хүн бүр вакцин хийлгэх хэрэгтэй юу?

Ихэнх улс орнуудад хүмүүсийн дийлэнх нь COVID-19-ийг үүсгэдэг вируст өртөмтгий хэвээр байна. Тиймээс улс орнууд хүн амын янз бүрийн бүлэгт вакцины харьцангуй хэрэгцээг үнэлэх шаардлагатай болно. Үүнд COVID-19-ийн халдварт хэн хамгийн их өртөх эрсдэлтэй, хэн хүнд хэлбэрээр өвчлөх эрсдэлтэй, эсвэл нас барах эрсдэлтэй зэрэг хүчин зүйлийг судлах шаардлагатай болно.

COVID-19 вакцин хийх хүн амын бүлгийг эрэмбэлэх замын зураглал нь ([Roadmap for Prioritizing Population Groups for Vaccines against COVID-19](#)) вакцины хүртээмж, нөхцөл байдлын янз бүрийн түвшний үед авч хэрэгжүүлэх нийгмийн эрүүл мэндийн стратеги, зорилтот бүлгүүдийг санал болгодог. Тэргүүн эгнээний зорилтот бүлгүүдийн жишээнд халдвар авах өндөр эрсдэлтэй орчинд ажиллаж байгаа эрүүл мэндийн болон асрамжийн газрын ажилтнууд, ахмад настнууд, зүрх судасны өвчин, чихрийн шижин гэх мэт суурь өвчний улмаас нас баралтын өндөр эрсдэлтэй хүмүүс орно.

#### 2. COVID-19 вакцин үр дүнтэй юу?

Цөөхөн вакцинд нэр дэвшигчдийн анхны тоо баримтуудаас харахад урам өгөхөөр байна. Гэсэн хэдий ч эдгээр нь вирусаас хамгаалахад хэр үр дүнтэй байх, энэ хамгаалалт хэр удаан үргэлжлэхийг тодорхойлоход илүү их мэдээлэл шаардлагатай.

Вакцины үр нөлөөнд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйл байдаг. Тухайлбал тухайн хүний нас, суурь өвчин, урьд өмнө нь энэ өвчнөөр өвчилж байсан эсэх г.м. Вакцины өөрийн онцлог шинж чанарууд - түүний найрлага, хийх арга, амьд эсвэл

идэвхгүйжүүлсэн эсэх гэх мэт хүчин зүйлээс хамааран түүний үр нөлөөг тодорхойлдог.

Одоо байгаа вакцинуудын хувьд ч гэсэн вакцин хийлгэсний дараа хүлээж байсан шиг дархлаа үүсэхгүй байх, үүссэн хамгаалалт нь удаан үргэлжлэхгүй байх зэрэг байдал хүмүүсийн цөөн хувьд тохиолддог. Зарим вакцин нь өвчний эсрэг хангалттай хамгаалалтыг хадгалахын тулд нэмэлт тунг шаарддаг.

COVID-19-ийн цар тахлаас өмнөх амьдралын хэв маягт хэсэг хугацааны турш буцаж чадахгүй байж магадгүй юм. Вирус хаа нэг газарт байгаа үед бүх улс орнууд эрсдэлтэй хэвээр байна. Вакцин нэвтрүүлсэн ч гэсэн хүн хоорондын зай барих, амны хаалт зүүх, гар угаах, амьсгалын замын эрүүл ахуйг сахих зэрэг арга хэмжээг авсаар байх ёстой.

### ***3. COVID-19 вакцинуудыг хурдан хугацаанд бүтээж байгаа нь вакцины аюулгүй байдлыг хангахад шаардлагатай алхамуудыг тэд алгассан гэсэн үг үү?***

Өмнө нь вакциныг олон жилийн туршид хэд хэдэн шат дамжлагаар боловсруулж ирсэн. Одоо бол COVID-19 вакцины яаралтай хэрэгцээ, вакцин боловсруулах дэвшилтэт технологи, урьд өмнө байгаагүй санхүүгийн хөрөнгө оруулалт, шинжлэх ухааны хамтын ажиллагаа нь вакцин боловсруулах арга хэлбэрийг өөрчилж байна. Ердийн үйл явцын үед хийдэг ямар ч алхамыг орхигдуулаагүй - ямар ч булангуудыг огтлоогүй. Судалгаа, боловсруулалтын үйл явцын зарим үе шатууд зэрэгцэн явагдаж байгаа бөгөөд аюулгүй байдал, үр ашгийн чанарын стандартад нийцсэн хэвээр байна.

### ***4. ДЭМБ -аас хэнд хамгийн түрүүнд вакцин хийх талаар ямар зөвлөмж өгч байгаа вэ?***

ДЭМБ-ын Дархлаажуулалтын Шинжээчдийн Стратегийн Зөвлөх Багаас (SAGE-ДШСЗБ) гишүүн орнуудад зориулан хязгаарлагдмал нийлүүлэлтийн үед COVID-19 вакцины хэрэглээг эрэмбэлэхэд туслах замын зураглал боловсруулсан. ДШСЗБ-ийн

зөвлөмж болгосон тэргүүлэх бүлгүүдэд өндөр эрсдэлтэй орчинд эхний тусламж үйлчилгээ үзүүлэгчид буюу эрүүл мэндийн ажилтнууд, ахмад настан, суурь өвчтэй хүмүүс багтаж байна. ДЭМБ гишүүн орнуудтайгаа COVID-19 вакциныг хэрхэн хэрэглэх талаар зөвлөн ажиллаж байна.


### 5. COVID-19 вакцины ялгаатай ямар төрлүүд бүтээгдэж байгаа вэ?

Одоогоор вакцины янз бүрийн технологи ашиглан бүтээсэн коронавирусийн эсрэг олон төрлийн вакцин эмнэлзүйн туршилтанд байна. Үүний үр дүнд дархлааны хариу урвалын хүч, шаардлагатай тунгийн тоо, аюулгүй байдлын шинж чанарууд, хүйтэн хэлхээний шаардлага, үйлдвэрлэх хугацаа зэрэг шинжүүд нь ялгаатай янз бүрийн шинж чанар бүхий вакцинууд бий болно.

Вакцины төрөл	Тайлбар	Вакцины жишээ
<b>Идэвхгүйжүүлсэн вирусийн вакцин</b>	Вирусийн идэвхгүйжүүлсэн хэлбэр. Вирус нь дархлааны эсүүдээр танигдана, өвчин үүсгэх чадваргүй.	Галзуугийн вакцин
<b>Шингэрүүлсэн амьд</b>	Бай эмгэг төрүүлэгчийг амьд боловч сулруулсан байдлаар агуулдаг.	Улаан бурханы вакцин
<b>Вирусийн векторт вакцин</b>	Бай эмгэг төрүүлэгчийг агуулсан генийн инженерчлэлийн аргаар гаргасан вирус. Нуклейн хүчлийг хүний эсэд суулгасан үед тэдгээр нь вирусийн уургийг хувилж олшруулан улмаар эзэн биеийн дархлаа тогтолцооны хамгаалах хариу урвалыг өдөөдөг.	Эболагийн вакцин

<b>Нуклейн хүчлийн вакцин</b>	РНХ эсвэл ДНХ вакцинууд нь бай эмгэг төрөгчийн дархлааны урвал өдөөдөг уургийн мэдээллийг агуулдаг. Нуклейн хүчлийг хүний эсэд суулгахад РНХ эсвэл ДНХ нь эсрэг төрөгчид хувирдаг.	Шинэ вакцины технологи
<b>Вирус төст вакцин</b>	Генетикийн материал агуулаагүй, бай эмгэг төрүүлэгчтэй төстэй вирусийн гадна бүрхүүл. Вирусийн гадна бүрхүүл нь эзэн биеийн хамгаалах дархлааны урвалыг өдөөнө.	Хүний хөхөнцөр вирусийн эсрэг вакцин
<b>Уургийн хэсэг бүхий вакцин</b>	Эдгээр вакцинууд нь дархлаанд чухал нөлөөтэй бай эмгэг төрүүлэгчийн хэсгүүдийг ашигладаг.	В гепатитын эсрэг вакцин

## Types of vaccines that are likely to be available in the short term

	Type	Dose/s	Efficacy*	Storage	Cost/dose
 Moderna/NINAIID	RNA		95%	-20°C (6 mos.)	10-37 USD
 BioNTech/Fosun  Pharma/Pfizer	RNA		95%	-70°C	20 USD
 University of Oxford/ AstraZeneca	Non-replicating Viral Vector		62%-90%	2-8°C, 20°C	3-4 USD
 Gamaleya Center (Sputnik V)	Non-replicating Viral Vector		91%	2-8°C, -20°C	10 USD
 Sinovac Biotech	Inactivated		-	2-8°C	30 USD
 Wuhan Inst. of Bio. Products/Sinopharm	Inactivated		-	2-8°C	72 USD
 Beijing Inst. of Bio. Products/Sinopharm	Inactivated		-	2-8°C	72 USD
 Cansino Bio. Inc./ Beijing Inst. of Biotech.	Non-replicating Viral Vector		-	2-8°C	-
 Janssen Pharma. Cos.	Non-replicating Viral Vector		-	2-8°C, -20°C	10 USD
 Novavax	Protein subunit		-	2-8°C	16 USD
 Bharat Biotech	Inactivated		-	2-8°C	-

\*Preliminary phase three results, not yet peer-reviewed



COVID-19 вакцины нөхцөл байдлын дүн шинжилгээг ДЭМБ тогтмол шинэчилж байна ([www.who.int/publications/m/item/draft-landscape-of-covid-19-candidate-vaccines](http://www.who.int/publications/m/item/draft-landscape-of-covid-19-candidate-vaccines)).

**6. COVID-19 вакцины чанарын хяналтанд ДЭМБ ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? ДЭМБ-аас COVID-19 вакцины талаар ямар нэгэн дэлхийн стандарт тогтоосон уу ?**

Вакцин ашиглах зөвшөөрлийг чанарын хяналт, вакцины аюулгүй байдал, үр нөлөөг үнэлэх үүрэг бүхий үндэсний зохицуулах байгууллагууд гаргана. ДЭМБ-аас COVID-19 вакцины бүтээгдэхүүний танилцуулгыг (target product profiles for COVID-19 vaccines) гаргасан бөгөөд үүнд COVID-19-ийн өндөр эрсдэлтэй хүмүүсийг удаан хугацаагаар хамгаалах вакциныг илүүд үзэж байгаа болон зөвшөөрөгдөх хамгийн бага шинж чанарыг тодорхойлсон болно.

**7. COVID-19 вакцины ямар гаж нөлөө байж болох вэ?**

Вакциныг хэрэглэх зөвшөөрөл авахаас өмнө аюулгүй байдал, үр дүнтэй байдлыг үндэсний зохицуулах байгууллагууд хянадаг. COVID-19 вакцины зарим үйлдвэрлэгчид вакцин хийлгэсэн хүмүүсийн зарим нь ердийн дархлаажуулалттай адил халуурах, толгой өвдөх, булчингаар өвдөх, тарилга тарьсан хэсэгт улайх гэх мэт хөнгөн, дунд зэргийн гаж нөлөөг мэдэрсэн гэж олон нийтэд мэдээлсэн байна. Вакцин нэвтрүүлсний дараа аливаа шинэ вакцины нэгэн адил дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг сайтар судалж, хянах шаардлагатай юм.

**8. COVID-19 вакцины хувьд хичнээн тун хийлгэх шаардлагатай вэ?**

Энэ нь боловсруулж буй вакцины төрлөөс хамаарна. Одоогоор боловсруулж буй COVID-19 вакцинуудын хувьд дархлааны хариу урвалыг өдөөхөд заримд нь нэг тун шаардлагатай байгаа бол ихэнхэд нь хоёр тун шаардлагатай байна.

## **9. COVID-19 вакцины дархлаа хэр удаан үргэлжлэх вэ?**

COVID-19 вакцин нь урт хугацааны дархлаа тогтоох эсэхийг хэлэхэд эрт байна. Вакцинд нэр дэвшигчдийн нэг буюу хэд хэд нь халдвараас хамгаалахад аюулгүй, үр дүнтэй байх болно гэж үзэж байгаа ч аль нь хэр зэрэг үр дүнтэйгээр вирусийн эсрэг хамгаалалт үүсгэж, тэр нь хэр удаан үргэлжлэх нь одоогоор бүрэн гүйцэд судлагдаагүй байна. Энэхүү асуултанд хариулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Одоогоор байгаа мэдээллүүдээс харахад COVID-19-р өвчлөөд эдгэрсэн хүмүүсийн ихэнх нь дархлааны хариу урвал үзүүлж, дахин халдварлалтаас дор хаяж тодорхой хэмжээгээр хамгаалж чаддаг болохыг харуулж байгаа нь урам зориг өгч байгаа ч энэ хамгаалалт нь хэр хүчтэй болох, хэр удаан үргэлжлэх талаар судалсаар байна.

Вакцины үр нөлөөнд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйл байдаг, тухайлбал тухайн хүний нас, суурь өвчнүүд, тухайн халдварт урьд нь өртөж байсан эсэх г.м. Мөн вакцины өөрийн онцлог шинж чанарууд - түүний найрлага, хүргэх арга хэлбэр, амьд эсвэл идэвхгүй эсэх зэрэг нь түүний үр нөлөөг тодорхойлдог.

Одоо байгаа вакцинуудын хувьд ч гэсэн вакцин хийлгэсний дараа хамгаалалт үүсэхгүй байх, үүссэн хамгаалалт нь удаан үргэлжлэхгүй байх г.м байдал хүмүүсийн цөөн хувьд тохиолддог. Зарим вакцин нь өвчний эсрэг хангалттай хамгаалалтыг хадгалахын тулд нэмэлт тунг шаарддаг.

## **10. Миний хүүхдүүд дархлаажуулалтад хамрагдаж чадах уу?**

Хүүхдэд COVID-19 вакцин хийх ажил эхлээд удаагүй, зарим насныханд хийх эсэх нь тодорхой болоогүй байгаа тул хүүхдүүдэд болон эцэг, эхчүүдэд вакцины аюулгүй байдал, үр дүнгийн талаархи мэдээлэл бүрэн хүрээгүй байна. Тиймээс эцэг эхчүүд хүүхдүүдээ халдвараас сэргийлэх зан үйлээ үргэлжлүүлэхийг нь дэмжих шаардлагатай (жишээлбэл, амны хаалт зүүж, гарын ариун цэврийг сахин, хүн хоорондын зай барьж, бие нь тавгүйтвэл хичээлдээ явалгүй гэртээ байх).

### **11. Жирэмсэн эмэгтэйчүүд вакцин хийлгэж болох уу?**

Ерөнхийдөө жирэмсэн эмэгтэйчүүдийг вакцины эмнэлзүйн туршилтад хамруулдаггүй бөгөөд үүнд COVID-19 вакцин ч багтаж байна. Жирэмсэн үед онолын хувьд гарч болох сөрөг үр дагаврын эрсдэлийг харгалзан үзэж ихэнх вакциныг жирэмсэн эмэгтэйчүүдэд зөвлөдөггүй. III шатны эмнэлзүйн туршилтын үеэр жирэмсэн болсон оролцогчдод жирэмсэн үеийн аюулгүй байдлын судалгаа хийж, жирэмсний үеийн тоо баримт гаргах шаардлагатай байна.

### **12. Настай хүмүүсийн хувьд ямар вэ? Тэдний хувьд вакцин аюулгүй бөгөөд үр дүнтэй байх уу?**

Ахмад настнуудад аюулгүй, дархлааны хүчтэй хариу урвал үүсгэдэг COVID-19 вакцинтай болох нь цар тахлын эсрэг цогц хариу арга хэмжээний чухал хэсэг байх болно. Ахмад настнууд, архаг суурь өвчинтэй хүмүүс COVID-19-тэй холбоотойгоор хүндээр өвчилж байна. Түүнчлэн нас баралтын тохиолдол ахмад настай хүмүүсийн дунд хамгийн өндөр байна. Дэлхийн хэмжээнд COVID-19 нь урт хугацааны асрамжийн газрын оршин суугчдад харьцангуй ихээр нөлөөлж, өвчлөл, нас баралт, түүнчлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг өндөр байгааг нотолж байгаа олон баримт байна.

### **13. Зарим COVID-19 вакцинууд дотооддоо зөвшөөрөл авахаар өргөдлөө өгчээ. Вакцин нэвтрүүлэлтийг удаашруулж болох саадууд юу байж болох вэ?**

2020 оны дунд үеэс эхлэн ДЭМБ гишүүн орнуудтайгаа COVID-19 вакцин нэвтрүүлэхэд эрүүл мэндийн тогтолцоогоо бэлэн байлгах талаар хамтран ажиллаж байна. Үүнд сайн бэлтгэгдсэн тэргүүн эгнээний ажилтнууд, хүйтэн хэлхээний зохих дэд бүтэц ба менежмент, зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх, вакцинжуулалтын талаархи харилцаа холбоо, олон нийтийн оролцоо зэрэг багтана.

Вакцины талаар дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/covid-19-vaccines> линкээр авч болно.

## НАЙМ. КОВИД-19 ВАКЦИНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ХЭРХЭН ХҮРГЭХ ВЭ?

### Олон нийтэд мэдээлэл хүргэх аргыг ашиглах зааварчилгаа:

Энэ аргын зорилго нь уламжлалт болон орчин үеийн цахим мэдээллийн сувгуудыг ашиглан олон нийтэд мэдээллийг хүргэж, мэдлэгтэй болгоход чиглэнэ.

Мэдээ мэдээллийг үр дүнтэй хүргэснээрээ иргэд олон нийт Ковид-19 вакцины талаарх шаардлагатай мэдээллээр хангагдаж, улмаар вакцинд итгэх итгэл нь нэмэгдэнэ. Нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж байгаа энэ үед хэвлэл мэдээллийнхэн хамгийн зөв мэдээллээр иргэдийг хангаж, ингэснээр дархлаажуулалттай холбоотой, тухайлбал худал мэдээллээс улбаатай ирээдүйд учрах эрсдэлээс олон нийтийг хамгаалж чадна. Мэдээ мэдээллийг үр дүнтэй хүргэх нь олон нийтийн вакцинд итгэх итгэлийг бий болгох, батжуулах үндэс юм.

### Ковид -19-н вакцины тухай мэдээ мэдээллийг хүргэхэд баримтлах зарчим:

1. Вакцины талаар одоо мэдэгдэж байгаа болон мэдэгдэхгүй байгаа зүйлсийн талаар хоёуланг нь тайлбарла
2. Тухайн нөхцөлд хэвлэл мэдээллээр олон нийтийн асуултад хариулах боломжгүй буюу хариултыг сэтгүүлч мэдэхгүй бол одоохондоо хариулах боломжгүйгээ хүлээн зөвшөөрч, боломжтой бол дараа нь асуултад хариулах
3. Ковид-19-н вакцины талаар итгэл үнэмшил төрүүлэхдээ иргэд, олон нийтийн үнэт зүйлд хүндэтгэлтэй хандах
4. Вакцинтай холбоотой гарч болох эрсдэлийг тодорхой тайлбарлаж, гарч болох эрсдэлд хүмүүсийг бэлтгэх ( Тухайлбал: вакцины дараах урвал хүндрэл гэх мэт)
5. Өөрийгөө болон бусад хүмүүсийг халдвараас хамгаалах энгийн зүйлс болох гар угаах, амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн дагаж мөрдөхийг тогтмол зөвлөх

**Практик зөвлөгөө:**

- Бусдын оронд өөрийгөө тавьж, ойлгож хүндэтгэж байгаагаа харуулах
- Асууж буй асуултыг анхааралтай сонсох, бусдын үзэл бодлын зөрүүтэй байдлыг хүндэтгэх
- Энгийн, тодорхой хэлж ярих, бүдүүлэг үг хэллэг ашиглахгүй байх
- Дахин дахин баталж хэлэх эсвэл амлалт өгөхгүй байх,

**Дархлаажуулалтын үед сэтгүүлч, редакторууд олон нийтэд түгээж болох мессежийн жишээ**

<b>Үндсэн мессэж</b>	<b>Нэмэлт мессэж</b>
Үр дүнтэй, аюулгүй вакциныг бусад арга хэмжээтэй хослуулан хэрэглэснээр коронавирусийн халдвараас сэргийлж, улмаар олон хүн амь насаа алдахаас сэргийлнэ.	ДЭМБ, НҮБХС болон бусад хамтрагч байгууллагууд үр дүнтэй, аюулгүй вакциныг бүх улс орны халдвар авах өндөр эрсдэлтэй хүмүүст КОВАКС санаачлагаар дамжуулан аль болох хурдан хүргэх ажлыг хамтран хийж байна. Энэхүү санаачлага нь улс орон бүрийг Ковид19-ийн вакцинаар адил тэнцүү хангах зорилготой юм. Нийт 180 гаруй улс энэхүү санаачлагад нэгдээд байна.
	Гэвч энэ цар тахалтай тэмцэхэд зөвхөн вакцинтай байхад хангалтгүй бөгөөд өвдсөн хүнийг илрүүлэх, хавьтлыг тусгаарлах, хүн хоорондын зай барих, гараа тогтмол угаах, амны хаалт зүүх, олон хүнтэй газар явахгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх ёстой.
Шинэ вакциныг баталгаажуулах үйл явц нь нарийн	ДЭМБ, НҮБХС болон бусад хамтрагч байгууллагууд өндөр үр дүнтэй, аюулгүй вакциныг хурдан бүтээх үйл ажиллагааг дэмжин тусалдаг.

<p>стандартын дагуу явагдана.</p>	<p>Нэг вакцины баталгаажуулалт хийгдэж байхад өөр олон вакцины судалгаа үргэлжилсээр байгаа. Учир нь вакцины хэрэгцээ асар их байна. Вакциныг хэрэглэхэд бэлэн болгох хүртэл олон шат дамжлагыг дамжих шаардлагатай бөгөөд эдгээрийг алгасаж хийх боломжгүй.</p>
	<p>Тухайн улсын үндэсний эрх бүхий байгууллага баталгаажуулалт хийсний үндсэн дээр вакциныг хэрэглэхийг зөвшөөрнө.</p>
	<p>Вакциныг хийж эхэлсний дараа вакциныг хянах ажил үргэлжлүүлэн хийгдэнэ. Энэ үйл ажиллагаа нь шинэ болон бусад товлолын вакцины үед ч хийгддэг. Вакцин хийлгэсний дараа гарч болох урвал, хүндрэлийг маш нарийн судлах бөгөөд энэ нь шинэ вакцин бүрт хийгддэг ажил юм.</p>
<p>Ковид-19-н вакцин хүн бүрт хүртээмжтэй болтол тодорхой хугацаа шаардагдана.</p>	<p>Тухайн улс вакциныг хэрэглэхийг зөвшөөрсөн боловч эхлээд хязгаарлагдмал тооны вакцин улс орнуудад тараагдана.</p>
<p>Улс орнууд эхний ээлжинд ямар хүмүүсийг вакцинд хамруулахаа шийдэх хэрэгтэй. Шударга, тэгш хүртээх зарчмыг баримтлах нь чухал.</p>	<p>Вакциныг улс орнууд хүлээн авмагц зохих нөхцөлд хадгалж, улмаар хүрэхэд бэрхшээлтэй хүн амыг вакцинжуулна.</p> <p>Тухайн улс өөрийн нөхцөл байдалд тулгуурлан эхний ээлжинд вакцин хийлгэх шаардлагатай хүн амыг тодорхойлно.</p> <p>Халдвар авах хамгийн их эрсдэлтэй хүн амд вакциныг эхэлж хийх нь чухал. Үүнд: эрүүл мэндийн ажилчид болон өндөр настай, архаг хууч өвчтэй хүмүүсийг вакцинжуулахыг ДЭМБ-аас зөвлөж байгаа.</p>

<p>Вакцин нь бүхнийг шийддэг шидэт зүйл биш</p>	<p>Коронавирусийн халдвартай тэмцэхэд вакцин чухал боловч хамгийн үр дүнтэй вакцин ч дангаараа цар тахлыг таслан зогсоож чадахгүй.</p>
	<p>Учир нь вакцинаар үүсэх дархлаа нь халдвараас хэр удаан хамгаалах нь одоогоор тогтоогдоогүй байна. Тиймээс бид халдвараас сэргийлэх бусад арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх хэрэгтэй.</p>
	<p>Хүн болгон өөрийгөө болон бусдыг халдвар авахаас сэргийлэх алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд гараа угаах, амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, түүнчлэн хавьтлыг илрүүлэх, тусгаарлах болон бусад нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.</p>

*Хэвлэл мэдээллийн редактор, сэтгүүлчдэд зориулсан энэхүү сургалтын гарын авлагыг бэлтгэхэд шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний материалууд, мэргэжлийн мэдээллээр хангасан ДЭМБ, ХӨСҮТ, НЭМҮТ, ЭМЯ зэрэг байгууллагад гүн талархал илэрхийлье.*

## **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗӨВЛӨЛ**